

БАЙГАЛЬ ОРЧНЫ ОРОН НУТГИЙН ЗАРЛАГЫН ШИНЖИЛГЭЭ

Хандлага болон өнөөгийн
нөхцөл байдал

**Тогтвортой Хөгжлийн 2030
хөтөлбөрийн хэрэгжилтэд
дэмжлэг үзүүлэх хөтөлбөр**

2022 он

Байгаль орчны орон нутгийн зарлагын шинжилгээ:

Хандлага (2015-2020) болон өнөөгийн нөхцөл байдал (2020 оны гүйцэтгэл) тайланг НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Тогтвортой Хөгжлийн 2030 хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх төслийн хүрээнд боловсруулав. Энэхүү тайлан нь НҮБХХ-ийн албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

АХБ	Азийн хөгжлийн банк
ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БНАТ	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
СЯ	Сангийн яам
ЗГ	Засгийн газар
ЗГСС (GFS)	Засгийн газрын санхүүгийн статистик
МУ	Монгол улс
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
НҮБХХ	Нэгдсэн үндэстний байгууллагын хөгжлийн хөтөлбөр
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОУВС	Олон улсын валютын сан
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилго
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УИХ	Улсын их хурал
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар

АГУУЛГА

ТӨСВИЙН ТУХАЙ	2
Нэгдсэн төсвийн тухай	2
Улс, орон нутгийн төсвийн харилцаа	3
Орон нутгийн төсөв	4
Орон нутгийн хөгжлийн сан	8
БАЙГАЛЬ ОРЧНЫ ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА	10
БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ШИНЖИЛГЭЭ	12
ОРОН НУТГИЙН ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧНЫ ХӨТӨЛБӨРИЙН ЗАРЛАГЫН ШИНЖИЛГЭЭ	20
Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр	25
Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх	28
Биологийн төрөл зүйлийн хамгаалалт	31
Нэн ховор, ховордсон амьтан, ургамлын хамгаалалт	34
Ойжуулалт	36
Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалт	39
Ус цаг уур, орчны шинжилгээ	41
Усны нөөц, нуур, гол мөрний менежмент	43
Хог хаягдал	44
Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага	45
Хүрээлэн буй орчны бохирдол, доройтол	48
ДҮГНЭЛТ, САНАЛ ЗӨВЛӨМЖ	51
ХАВСРАЛТУУД	54

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Орон нутгийн 2020 оны төсөв	4
Хүснэгт 2. Орон нутгийн 2020 оны төсвийн орлого, аймгаар	5
Хүснэгт 3. ОНХС бий болсноос хойшхи хууль эрх зүйн орчны өөрчлөлт, 2013-2020 оноор.....	8
Хүснэгт 4. Байгаль орчны орон нутгийн төсвийн байгууллагын 2020 оны нийт орлого, зарлага.....	11
Хүснэгт 5. 2013-2020 оны байгалийн нөөц ашигласны төлбөрийн биелэлт төвлөрсөн орлогын төрлөөр	14
Хүснэгт 6. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн дагуу 2015-2020 оны төвлөрүүлсэн орлого, зарлагын нэгтгэл	16
Хүснэгт 7. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн дагуу 2020 оны төвлөрүүлсэн орлого, зарлагын нэгтгэл	18
Хүснэгт 8. Байгаль орчны орон нутгийн төсвийн байгууллагын хүрээлэн буй орчин хөтөлбөрийн 2015-2020 оны гүйцэтгэл	22
Хүснэгт 9. Байгаль орчны орон нутгийн 2020 оны хөтөлбөрийн төлөвлөгөө, гүйцэтгэл.....	23
Хүснэгт 10. Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн 2020 оны төлөвлөгөө, гүйцэтгэл аймаг, нийслэлээр болон байгууллагаар	26
Хүснэгт 11. Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн 2020 оны төлөвлөгөө, гүйцэтгэл аймаг, нийслэлээр, байгууллагаар болон эдийн засгийн ангиллаар.....	27
Хүснэгт 12. Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн 2020 оны арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, хувь	28
Хүснэгт 13. Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх хөтөлбөрийн 2020 оны төлөвлөгөө, гүйцэтгэл байгууллагаар болон аймгаар.....	29
Хүснэгт 14. Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх хөтөлбөрийн 2020 оны арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, хувь	31
Хүснэгт 15. Биологийн төрөл зүйлийн хамгаалалт хөтөлбөрийн 2015 оны төлөвлөгөө, гүйцэтгэл хөтөлбөр, арга хэмжээ болон аймгаар.....	32
Хүснэгт 16. Биологийн төрөл зүйлийн хамгаалалт хөтөлбөрийн 2016-2017 оны гүйцэтгэл хөтөлбөр, арга хэмжээ болон аймгаар	32
Хүснэгт 17. Биологийн төрөл зүйлийн хамгаалалт хөтөлбөрийн 2018 оны төлөвлөгөө, гүйцэтгэл хөтөлбөр, арга хэмжээ, аймаг болон байгууллагаар	33
Хүснэгт 18. Биологийн төрөл зүйлийн хамгаалалт хөтөлбөрийн 2019 оны төлөвлөгөө, гүйцэтгэл аймаг, хөтөлбөр, арга хэмжээ болон эдийн засгийн ангиллаар	33
Хүснэгт 19. Нэн ховор, ховордсон амьтан, ургамлын хамгаалалт хөтөлбөрийн 2015-2018 оны гүйцэтгэл нийслэл, байгууллага, хөтөлбөр болон арга хэмжээгээр.....	35
Хүснэгт 20. Нэн ховор, ховордсон амьтан, ургамлын хамгаалах хөтөлбөрийн 2019 оны төлөвлөгөө, гүйцэтгэл нийслэл, байгууллага, хөтөлбөр болон арга хэмжээгээр.....	35
Хүснэгт 21. Нэн ховор, ховордсон амьтан, ургамлын хамгаалалт хөтөлбөрийн 2019 оны төлөвлөгөө, гүйцэтгэл нийслэл, байгууллага, хөтөлбөр, арга хэмжээ болон эдийн засгийн ангиллаар.....	35
Хүснэгт 22. Ойжуулалт хөтөлбөрийн 2020 оны төлөвлөгөө, гүйцэтгэл байгууллага болон аймгаар .	37
Хүснэгт 23. Ойжуулалт хөтөлбөрийн 2020 оны арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, гүйцэтгэлийн хувь	39

Хүснэгт 24. Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалт хөтөлбөрийн 2017 болон 2018 оны төлөвлөгөө, гүйцэтгэл аймаг, байгууллага, хөтөлбөр, арга хэмжээ болон эдийн засгийн ангиллаар	41
Хүснэгт 25. Ус цаг уур, орчны шинжилгээ хөтөлбөрийн 2020 оны төлөвлөгөө, гүйцэтгэл аймаг, байгууллага, хөтөлбөр болон арга хэмжээгээр	42
Хүснэгт 26. Усны нөөц, нуур, гол мөрний менежмент хөтөлбөрийн 2015 оны төлөвлөгөө, гүйцэтгэл аймаг, байгууллага, хөтөлбөр, арга хэмжээ болон эдийн засгийн ангиллаар.....	44
Хүснэгт 27. Хог хаягдлын хөтөлбөрийн 2019 оны төлөвлөгөө, гүйцэтгэл аймаг, байгууллага, хөтөлбөр болон арга хэмжээгээр.....	44
Хүснэгт 28. Хог хаягдлын хөтөлбөрийн 2020 оны төлөвлөгөө, гүйцэтгэл аймаг, байгууллага, хөтөлбөр болон арга хэмжээгээр.....	45
Хүснэгт 29. Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага хөтөлбөрийн 2020 оны төлөвлөгөө, гүйцэтгэл байгууллага болон аймгаар.....	46
Хүснэгт 30. Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага хөтөлбөрийн 2020 оны арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, хувь	47
Хүснэгт 31. Хүрээлэн буй орчны бохирдол, доройтол хөтөлбөрийн 2020 оны төлөвлөгөө, гүйцэтгэл байгууллага болон аймгаар.....	49
Хүснэгт 32. Хүрээлэн буй орчны бохирдол, доройтол хөтөлбөрийн 2020 оны арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, хувь	50
Хүснэгт 33. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн дагуу 2015 оны төвлөрүүлсэн орлого, зарлагын нэгтгэл	54
Хүснэгт 34. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн дагуу 2016 оны төвлөрүүлсэн орлого, зарлагын нэгтгэл	54
Хүснэгт 35. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн дагуу 2017 оны төвлөрүүлсэн орлого, зарлагын нэгтгэл	55
Хүснэгт 36. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн дагуу 2018 оны төвлөрүүлсэн орлого, зарлагын нэгтгэл	55
Хүснэгт 37. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн дагуу 2019 оны төвлөрүүлсэн орлого, зарлагын нэгтгэл	56
Хүснэгт 38. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн дагуу 2020 оны төвлөрүүлсэн орлого, зарлагын нэгтгэл	56
Хүснэгт 39. Байгаль орчны орон нутгийн хөтөлбөрийн 2020 оны арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл	57
Хүснэгт 40. Байгаль орчны орон нутгийн хөтөлбөрийн 2020 оны төлөвлөгөө, гүйцэтгэл байгууллага болон аймгаар	58

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төсвийн бүрэлдэхүүн, үе шат	2
Зураг 2. Улсын төсөв, орон нутгийн төсөв хоорондын харилцаа	3
Зураг 3. Орон нутгийн 2020 оны төсвийн гүйцэтгэл	4
Зураг 4. Орон нутгийн 2020 оны төсвийн зарлага эдийн засгийн ангиллаар	6
Зураг 5. Орон нутгийн 2020 оны төсвийн зарлагын гүйцэтгэл	7
Зураг 6. ОНХС-аас сумдад шууд хуваарилах ашигт малтмалын эх үүсвэрүүд.....	9

Зураг 7. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан 2020 он	9
Зураг 8. Байгаль орчны орон нутгийн төсвийн байгууллагын 2020 оны нийт орлого, зарлага	10
Зураг 9. 2013-2020 оны байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө болон гүйцэтгэл	13
Зураг 10. 2013-2020 оны байгалийн нөөц ашигласны төлбөрийн биелэлт төвлөрсөн орлогын төрлөөр	14
Зураг 11. 2013-2020 оны байгалийн нөөц ашигласны төлбөр аймгаар, орлогын төрлөөр	15
Зураг 12. 2020 оны байгалийн нөөц ашигласны төлбөр аймгаар, орлогын төрлөөр	17
Зураг 13. 2020 оны аймаг, нийслэлийн Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт	19
Зураг 14. Орон нутгийн төсөвт эзлэх байгаль орчны зардал, эзлэх хувь	20
Зураг 15. Байгаль орчны зардлын орон нутгийн төсөвт эзлэх хувь	21
Зураг 16. Сангийн сайдын 2015 оны 7-р тушаалаар баталсан Төсвийн зарлагын хөтөлбөрийн ангилал	21
Зураг 17. Байгаль орчны орон нутгийн 2020 оны хөтөлбөр болон эдийн засгийн ангилал	23
Зураг 18. Байгаль орчны орон нутгийн 2020 оны хөтөлбөрийн гүйцэтгэл	24
Зураг 19. Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн 2015-2020 оны гүйцэтгэл	25
Зураг 20. Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн 2020 оны эдийн засгийн ангилал, арга хэмжээний ангилал	27
Зураг 21. Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх хөтөлбөрийн 2015-2020 оны төлөвлөгөө, гүйцэтгэл	28
Зураг 22. Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх хөтөлбөрийн 2020 оны эдийн засгийн ангилал, арга хэмжээний ангилал	31
Зураг 23. Биологийн төрөл зүйлийн хамгаалалт хөтөлбөрийн 2015-2020 оны төлөвлөгөө, гүйцэтгэл	31
Зураг 24. Нэн ховор, ховордсон амьтан, ургамлын хамгаалалт хөтөлбөрийн 2015-2020 оны төлөвлөгөө, гүйцэтгэл	34
Зураг 25. Байгаль орчны орон нутгийн нийт зардал болон ойжуулалт хөтөлбөрийн 2015-2020 оны гүйцэтгэл, эзлэх хувь	36
Зураг 26. Ойжуулалт хөтөлбөрийн 2020 оны эдийн засгийн ангилал, арга хэмжээний ангилал	39
Зураг 27. Монгол улсын тусгай хамгаалалттай газар нутаг	40
Зураг 28. Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалт хөтөлбөрийн 2015-2020 оны төлөвлөгөө, гүйцэтгэл	41
Зураг 29. Ус цаг уур, орчны шинжилгээ хөтөлбөрийн 2015-2020 оны төлөвлөгөө, гүйцэтгэл	42
Зураг 30. Усны нөөц, нуур, гол мөрний менежмент хөтөлбөрийн 2015-2020 оны төлөвлөгөө, гүйцэтгэл	43
Зураг 31. Хог хаягдлын хөтөлбөрийн 2015-2020 оны төлөвлөгөө, гүйцэтгэл	44
Зураг 32. Байгаль орчны орон нутгийн зардал болон хүрээлэн буй орчны бодлого, удирдлага хөтөлбөрийн 2015-2020 оны гүйцэтгэл	46
Зураг 33. Хүрээлэн буй орчны бохирдол, доройтол хөтөлбөрийн 2015-2020 оны төлөвлөгөө, гүйцэтгэл	49
Зураг 34. Байгаль орчны орон нутгийн 2020 оны төсөв эдийн засгийн ангиллаар	57

ОРШИЛ

Байгаль орчны орон нутгийн зарлагын шинжилгээний зорилго нь орон нутгийн байгаль орчны 2015-2020 оны төсвийн гүйцэтгэл дээр үндэслэн өнгөрсөн хугацааны хандлага болон өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлж, орон нутгийн төсөв, санхүүгийн удирдлагын талаар сүүлийн үеийн бодитой шинжилгээний мэдээллээр ханган НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Тогтвортой Хөгжлийн 2030 хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Орон нутгийн хүрээлэн буй орчны хөтөлбөрийн 2015-2020 оны орлого, зарлагын шинжилгээ, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, Засгийн Газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ийн хэрэгжилтийн 2013-2020 оны гүйцэтгэлд тус тус шинжилгээ хийж дүгнэлт, санал зөвлөмж боловсруулсан.

Монгол улсад үр дүнд суурилсан төсвийн төлөвлөлт, төсвийн дунд хугацааны зарлагын хүрээг нэвтрүүлэх ажлыг 2021 оноос түршилтын журмаар эхлүүлээд байна. Төсөв, санхүүгийн удирдлагыг сайжруулах, улсын төсвийн зарлагын үр ашиг, үр нөлөөг дээшлүүлэхэд төсвийн зарлагын шинжилгээ чухал үүрэг гүйцэтгэж байна. Энэхүү шинжилгээ нь орон нутгийн төсөв, санхүүгийн тогтолцооны талаар сүүлийн үеийн үнэн зөв мэдээлэл өгч, төсвийн зорилтот үр дүнг хангах, нэгдсэн төсвийн сахилга бат, хөрөнгийн эх үүсвэрийн стратеги хуваарилалт болон төрийн үйлчилгээг үр ашигтай хүргэхэд дэмжлэг үзүүлнэ.


Төсөв, түүний холбогдох баримт бичиг, Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн систем (ЗГСУМС), түүний холбогдох тайлагналын модулиас гарган авсан төсвийн сарын гүйцэтгэлийн мэдээ, Засгийн газрын нэгтгэсэн тайлангийн Э-тайлан системээс гарган авсан аудитлагдсан санхүүгийн тайлан болон нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланг байгаль орчны орон нутгийн зарлагын шинжилгээний гол эх сурвалж болгон ашиглав.

ТӨСВИЙН ТУХАЙ

Нэгдсэн төсвийн тухай

Монгол улсын нэгдсэн төсөв нь Улсын төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв, Эрүүл мэндийн даатгалын төсөв болон Орон нутгийн төсвөөс бүрддэг. УИХ нь Улсын төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийг баталдаг бол орон нутгийн төсвийг тухайн шатны ИТХ баталдаг (Зураг 1).

Зураг 1. Төсвийн бүрэлдэхүүн, үе шат




Улс, орон нутгийн төсвийн харилцаа

Байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглалтыг хангах бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны санхүүжилтэнд улсын болон орон нутгийн төсөв чухал үүрэг гүйцэтгэнэ.

- **Тусгай зориулалтын шилжүүлэг¹:** Аймаг, нийслэлийн Засаг дарга Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэхэд зориулж улсын төсвөөс олгох тусгай зориулалтын шилжүүлэг.
- **Төвлөрүүлэх орлого:** Орон нутгийн төсвийн суурь орлого нь суурь зардлаас их буюу ашигтай гарвал тухайн ашгаас тодорхой хувиар улсын төсөвт төвлөрүүлнэ.
- **Санхүүгийн дэмжлэг:** Орон нутгийн төсвийн суурь зарлага нь суурь орлогоос их буюу алдагдалтай бол улсын төсвөөс санхүүгийн дэмжлэг олгоно.
- **Орлогын шилжүүлэг:** Орон нутгийн төсвийг дэмжих зорилгоор дээд шатны төсвийн орлогоос орон нутгийн төсөвт олгох хөрөнгө.

Зураг 2. Улсын төсөв, орон нутгийн төсөв хоорондын харилцаа




¹ Төсвийн тухай хуулийн 4.1.23. “тусгай зориулалтын шилжүүлэг” гэж энэ хуулийн 61.1-д заасан чиг үүргийг санхүүжүүлэх зорилгоор тусгайлан тогтоосон зориулалт, нөхцөл, шаардлагын дагуу аймаг, нийслэлийн төсөвт улсын төсвөөс олгох хөрөнгийг;

Орон нутгийн төсөв

Орон нутгийн төсөв² нь аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-аас баталсан, ерөнхийлөн захирагчийн бүрдүүлэн, зарцуулах төсөв юм. Орон нутгийн төсөв нь аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвөөс бүрдэнэ³. Төсвийн алдагдалтай үед улсын төсвөөс санхүүгийн дэмжлэг олгодог бол ашигтай тохиолдолд улсын төсөвт орлого төвлөрүүлдэг. Уг шилжүүлгийн хэмжээг УИХ баталдаг.

Зураг 3. Орон нутгийн 2020 оны төсвийн гүйцэтгэл



Орон нутгийн 2020 оны төсвийн гүйцэтгэлээр нийт орлого 3,146.8 тэрбум төгрөг буюу 95.0 хувийн биелэлттэй, нийт зарлага 3,157.2 тэрбум төгрөг буюу 84.9 хувийн гүйцэтгэлтэй гарсан. Орон нутгийн төсвийн нийт орлогын 39.3 хувь 1,235.5 тэрбум төгрөгийг татварын орлогоос, 60.7 хувь 1,911.4 тэрбум төгрөгийг татварын бус орлогоос бүрдсэн (Зураг 3).

Хүснэгт 1. Орон нутгийн 2020 оны төсөв

/тэрбум төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	2020 оны		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	3,311.7	3,146.8	(164.9)
Татварын орлого	1,287.6	1,235.5	(52.2)
Орлогын албан татвар	827.9	828.9	0.9
Хөрөнгийн албан татвар	175.3	154.9	(20.4)
Бусад татвар, төлбөр, хураамж	284.5	251.8	(32.7)
Бусад нийтлэг төлбөр, хураамж	63.6	62.8	(0.7)

² Төсвийн тухай хуулийн 4.1.27. "орон нутгийн төсөв" гэж аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан, тухайн шатны төсөвт харьяалагдах ерөнхийлөн захирагчийн бүрдүүлж, хуваарилан зарцуулах төсвийг;

³ Төсвийн тухай хуулийн 21.2

Газрын төлбөр	153.5	119.7	(33.8)
Байгалийн нөөц ашигласны төлбөр	57.9	63.9	6.1
Бусад татвар	9.5	5.3	(4.2)
Татварын бус орлого	2,024.1	1,911.4	(112.7)
Нийтлэг татварын бус орлого	219.9	197.1	(22.8)
Хөрөнгийн орлого	1.5	1.2	(0.3)
Тусламжийн орлого	12.9	11.7	(1.2)
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	1,789.8	1,701.3	(88.4)
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,717.9	3,157.2	(560.7)
УРСГАЛ ЗАРДАЛ	2,996.7	2,592.7	(404.0)
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,357.3	2,171.2	(186.1)
ХҮҮ	6.4	6.4	0.0
ТАТААС	173.7	168.6	(5.1)
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	459.3	246.4	(212.9)
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	685.5	546.8	(138.7)
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	35.7	17.8	(17.9)
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	(406.2)	(10.4)	395.8
АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	406.2	10.4	(395.8)
Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	332.8	(10.4)	(343.2)
Өмч хувьчлал	73.4	20.8	(52.6)

Эх сурвалж: СЯ, Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан 2020 он

Татварын орлогын 70.0 хувь буюу 864.4 тэрбум төгрөг хувь хүний орлогын албан татвараар төвлөрсөн. Тайлант онд ХХОАТ-ын буцаалтаар иргэдэд 35.6 тэрбум төгрөгийг олгосон. Бусад татвар, төлбөр, хураамжийн орлогоор 251.8 тэрбум төгрөг төвлөрсөн. Татварын бус орлогын 89.0 хувь 201.7 тэрбум төгрөгийг улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг, 1,333.9 тэрбум төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын санхүүжилт, 165.7 тэрбум төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн шилжүүлгийн орлогууд тус тус бүрдүүлж байна (Хүснэгт 1).

Хүснэгт 2. Орон нутгийн 2020 оны төсвийн орлого, аймгаар

/сая төгрөг/

№	Үзүүлэлт	Татварын орлого		Татварын бус орлого	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Архангай	7,423.6	12,487.6	73,779.3	69,507.7
2	Баян-Өлгий	10,318.1	10,301.3	85,340.8	78,171.4
3	Баянхонгор	10,853.6	12,647.2	79,415.2	76,052.7
4	Булган	21,824.4	23,314.6	46,853.6	43,692.2
5	Говь-Алтай	6,910.6	8,372.2	63,872.2	61,283.4
6	Говь-сүмбэр	4,967.2	5,754.8	13,574.0	12,979.5
7	Дархан-Уул	23,279.4	25,316.3	51,660.8	50,187.9
8	Дорноговь	32,885.2	28,652.1	57,081.2	52,905.4

9	Дорнод	18,442.7	20,303.9	55,580.1	52,969.7
10	Дундговь	4,744.8	5,912.0	49,013.2	47,211.0
11	Завхан	8,248.4	9,292.4	71,850.1	69,571.1
12	Орхон	65,983.6	71,077.9	64,689.8	65,053.1
13	Өвөрхангай	11,812.4	14,189.8	87,337.5	82,908.9
14	Өмнөговь	107,401.9	110,738.8	80,946.3	65,198.0
15	Сүхбаатар	8,161.7	9,050.0	62,046.7	58,549.2
16	Сэлэнгэ	27,151.5	27,299.0	74,152.2	70,217.6
17	Төв	21,731.1	25,758.4	76,049.3	69,014.9
18	Увс	9,857.9	10,794.2	83,490.4	80,083.6
19	Улаанбаатар	851,020.5	759,576.2	595,970.7	567,203.0
20	Ховд	9,795.5	11,248.3	76,503.0	73,004.9
21	Хөвсгөл	13,009.2	16,531.3	105,341.6	100,086.4
22	Хэнтий	11,818.6	16,868.8	69,546.8	65,510.3
	ДҮН				

Эх сурвалж: СЯ, Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан 2020 он


Орон нутгийн төсвийн зарлагын бүтцийг эдийн засгийн ангиллаар авч үзвэл 2020 оны байдлаар нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 3,157.2 тэрбум төгрөг үүний 82.1 хувь буюу 2,592.7 тэрбум төгрөгийг үрсгал зардал, 17.3 хувь буюу 546.8 тэрбум төгрөгийг хөрөнгийн зардал, 0.6 хувь буюу 17.8 тэрбум төгрөгийг эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл эзэлж байна (Зураг 4). Орон нутгийн төсвөөс улсын төсөвт 175.3 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Зураг 4. Орон нутгийн 2020 оны төсвийн зарлага эдийн засгийн ангиллаар



Эх сурвалж: СЯ, Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан 2020 он

Зураг 5. Орон нутгийн 2020 оны төсвийн зарлагын гүйцэтгэл



Эх сурвалж: СЯ, Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан 2020 он

Орон нутгийн хөгжлийн сан

Тухайн шатны төсвийн ерөнхийлөн захирагч нь орон нутгийн хөгжлийг дэмжих зорилго бүхий орон нутгийн хөгжлийн сантай⁴ байна. Тухайн орон нутгийн иргэд олон нийтийн бодит хэрэгцээ шаардлагад нийцсэн, мөн тэдний санал санаачилгаар дэмжигдсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээнд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг зарцуулах бөгөөд тухайн орон нутгийн иргэдийн нийтийн хурал, ИТХ-ын шийдвэрээр баталгаажиж төсөвт тусгагдах ёстой.

ОНХС-ийн зарцуулалт:


- ОНХС нь аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн санд данстай байх бөгөөд сангийн орлого, зарлагыг зөвхөн энэхүү дансаар дамжуулан гүйцэтгэнэ;
- ОНХС-ийн тухайн төсвийн жилд зарцуулагдаагүй үлдэгдлийг дараагийн төсвийн жилийн ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрт тусган ИТХ-аар баталсны дагуу санхүүжүүлнэ.

Хүснэгт 3. ОНХС бий болсноос хойшхи хууль эрх зүйн орчны өөрчлөлт, 2013-2020 оноор


	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он
1. Дотоодын НӨАТ	25%	25%	25%	10%	5%	5%	5%	5%
2. АМНАТ	5%	5%	5%	5%	5%	5%	5%	5%
3. Газрын тосны Нөөц ашигласны төлбөр	-	-	30%	30%	30%	30%	30%	30%
4. Аймаг нийслэлээс дахин хуваарилах /үндсэн тэнцлийн ашгаас/	Үндсэн тэнцлийн ашгаас суурь зарлагатай тэнцэх хэсгийг тухайн шатны төсөвт үлдээж үлдэх хэсгийг ОНХС-д төвлөрүүлнэ.				/ ОНХС-д бус дээд шатны төсөвт төвлөрүүлэх/			
5. АМНАТ /мега-аас бусад/	-	-		-	10%	10%	10%	
6. АМНАТ-ийн орлогоос улсын чанартай төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэгчийн төлсөн нөөц ашигласны төлбөрийн орлогыг хассаны зөрүүний								10%
7. Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл	-	-		50%	50%	50%		100%
8. Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл	-	-						50%
9. Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл	-	-		30%	0%	0%	0%	
10. ОУ-ын төслөөс олгох урамшуулал/үр дүнгийн үзүүлэлтээр/	-	-	-	-	Шалгуур хангасан сумдад ОНХС-аас хуваарилагдах хөрөнгийн сумдад оногдох хэсгийн 25 хувьтай тэнцэх хэмжээгээр хуваарилна.			

⁴ Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 4.1.28. “орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан” гэж орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн тэнцвэртэй байдлыг хангах зорилгоор улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгохоор дахин хуваарилалт хийх хөрөнгийг;

Зураг 6. ОНХС-аас сумдад шууд хуваарилах ашигт малтмалын эх үүсвэрүүд⁵



Зураг 7. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан 2020 он




⁵ Иргэдийн төсөв 2020 он

БАЙГАЛЬ ОРЧНЫ ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА

Байгалийн унаган төрх, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалж, хойч үедээ өвлүүлэн үлдээх, байгалийн нөөц баялгийг хамгаалах, хомсдолоос сэргийлэх, зохистой ашиглах, нөхөн сэргэх боломжийг бүрдүүлэн, байгаль орчинд нийцтэй, хүртээмжтэй эдийн засгийн өсөлт, нийгмийн тогтвортой хөгжлийн үндэс болно. Иймд байгаль орчны орон нутгийн төсвийн байгууллагууд нь улс, орон нутгийн төсөв, иргэн ААНБ-ын хандив, тусламж, байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого зэрэг санхүүгийн эх үүсвэрээр байгаль орчны хууль эрх зүйн орчин, бодлогын баримт бичгийг хэрэгжүүлж, байгаль орчныг хамгаалах, нөөцийг зохистой ашиглах, шууд болон шууд бусаар сөрөг нөлөөлөл үзүүлдэг хүчин зүйлсийг бууруулахаар ажиллаж байна.

Зураг 8. Байгаль орчны орон нутгийн төсвийн байгууллагын 2020 оны нийт орлого, зарлага /сая төгрөг/



Байгаль орчны салбарын санхүүжилт нь хамрах хүрээний хувьд хязгаарлагдмал, ихэнхдээ улсын болон орон нутгийн төсөв, олон улсын байгууллагуудын санхүүжилт, байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого, болон хувь хүн, байгууллагын өргөсөн хандив, тусламжаар хязгаарлагдаж байна. Байгаль орчны орон нутгийн төсвийн байгууллагуудын 2020 оны төсвийн гүйцэтгэлээр нийт орлого 50,420.5 сая төгрөг буюу 73.1 хувийн биелэлттэй, нийт зарлага 50,406.5 сая төгрөг буюу 72.6 хувийн гүйцэтгэлтэй гарсан (Зураг 9). Байгаль орчны орон нутгийн төсвийн байгууллагын нийт орлогын 98.7 хувь 49,768.3 сая төгрөгийг төсвөөс санхүүжих, 1.2 хувь 592.1 сая төгрөгийг нийтлэг татварын бус орлого буюу төсөвт байгууллагын өөрийн орлого, үлдсэн 0.1 хувь 60.1 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого тус тус эзэлж байна (Хүснэгт 4).

Хүснэгт 4. Байгаль орчны орон нутгийн төсвийн байгууллагын 2020 оны нийт орлого, зарлага

/сая төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
НИЙТ ОРЛОГО	68,927.6	50,420.5
Нийтлэг татварын бус орлого	604.8	592.1
Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	439.7	441.7
Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	165.2	150.4
Тусламжийн орлого	68,262.7	49,768.3
Төсвөөс санхүүжих	68,262.7	49,768.3
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	60.1	60.1
НИЙТ ЗАРЛАГА	69,451.9	50,406.5
УРСГАЛ ЗАРДАЛ	69,442.1	50,396.7
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	68,850.0	49,822.9
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	13,624.9	12,922.1
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,812.2	1,651.5
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	525.3	470.1
Хангамж, бараа материалын зардал	21,434.5	10,583.6
Норматвт зардал	273.7	266.8
Эд хогшил, урсгал засварын зардал	483.8	328.8
Томилолт, зочны зардал	82.5	56.7
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээ төлбөр, хураамж	12,015.3	10,453.9
Бараа үйлчилгээний бусад зардал	18,597.9	13,089.5
ТАТААС	66.6	66.6
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	525.4	507.1
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	9.8	9.8

Эх сурвалж: СЯ, Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан 2020 он, Төсвийн сарын гүйцэтгэлийн мэдээ 2020 он

Байгаль орчны орон нутгийн төсвийн байгууллагын 2020 оны нийт зарлагын 99.98 хувь буюу 50,396.7 сая төгрөгийг урсгал зардал, хөрөнгийн зардлын хувьд 9.8 сая төгрөг төлөвлөж, зарцуулсан байна (Хүснэгт 4). Бараа, ажил үйлчилгээний зардлын бүтцийг авч үзвэл 2020 оны байдлаар энэхүү зардлын 25.9 хувь 14,573.6 сая төгрөг цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, 21.2 хувь 10,583.6 сая төгрөг хангамж, бараа материалын зардал, 21.0 хувь 10,453.9 сая төгрөг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, 26.3 хувь 13,089.5 сая төгрөг бараа үйлчилгээний бусад зардал тус тус эзэлж байна. Эдгээр 4 төрлийн зардал нийт бараа, ажил үйлчилгээний зардлын 94.4 хувийг эзэлж байна. Байгаль орчны орон нутгийн төсвийн байгууллага 2020 онд төсвийн нийт зарлагын 98.8 хувийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлсэн бол үлдсэн хэсгийг орон нутгийн төсөвт байгууллага өөрийн орлогоор санхүүжүүлсэн байна.

Байгаль орчны орон нутгийн төсвийн байгууллагын 2020 оны нийт зарлага 50,406.5 сая төгрөгийн дэлгэрэнгүй задаргааг Орон нутгийн хүрээлэн буй орчны хөтөлбөрийн зарлагын шинжилгээ хэсгээс харна уу.

БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ШИНЖИЛГЭЭ

Байгалийн нөөцийг нөхөн сэргээгдэх ба нөхөн үл сэргээгдэх гэж ангилах ба МУ-ын зохих хуулийн дагуу байгалийн нөөц ашигласан төлбөрийг⁶ төлөх ёстой. Байгалийн нөөц ашигласны төлбөрийг сум, дүүргийн Засаг даргын томилсон төлбөр хураах эрх бүхий албан тушаалтан орон нутгийн төсөвт төвлөрүүлж⁷, хуульд заасан төлбөрийн орлогын хувь, хэмжээний доод хязгаараар байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах зохицуулалттай. Төсөв, санхүүгийн төвлөрлийг сааруулж, төсвийг төлөвлөхөөс эхлээд төсвийн орлогыг бүрдүүлэх, захиран зарцуулах хүрээнд орон нутгийн эрх мэдэл, хариуцлагыг нэмэгдүүлэх замаар орон нутгийн бие даасан хөгжлийг хангах, орон нутгийн иргэдэд төрийн үйлчилгээг ойртуулах боломж бүрдүүлсэн.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нь тухайн жилийн байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төсвийн орлогыг Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд заасан хувь, хэмжээний доод хязгаар болон түүнээс дээш хэмжээгээр бүрдүүлэх саналыг тухайн шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулна⁸. Орон нутгийн Засаг дарга нь бүрдүүлсэн орлогын хэмжээнд үндэслэн тухайн жилийн төсвийн суурь зарлагын төлөвлөгөөнд хэрэгжүүлэх арга хэмжээг тусгаж, батлуулна.

Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулах хувь, хэмжээний доод хязгаарыг дараах байдлаар тогтооно⁹:

Байгалийн баялгийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төрөл	Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хувь, хэмжээний доод хязгаар /нийт орлогын дүнгээс хувиар/
1. Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийн орлого	15 хувь
2. Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого	50 хувь
3. Газрын нөөцийн төлбөрийн орлого	15 хувь
4. Ойн нөөц ашигласны төлбөрийн орлого	85 хувь
5. Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого	35 хувь

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга байгалийн нөөц ашигласны төлбөр хураах эрх бүхий албан тушаалтныг томилон ажиллуулж, байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг 2013-2020 онуудад нийт 575.6 тэрбум төгрөг төлөвлөж, 613.5 тэрбум төгрөг бүрдүүлж, 107 хувийн гүйцэтгэлтэй гарсан. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого 2015 оноос хойш жил бүр төлөвлөсөн хэмжээнээс давж биелж байна. Хуулийн дагуу төвлөрүүлсэн орлого жил бүр өсөн нэмэгдэж байгаа (Зураг 9) ба байгалийн нөөц ашигласны төлбөрийн нийт орлого 2013-2016 онуудад 50-70 тэрбум

⁶ Байгалийн нөөц ашигласны төлбөр гэдэг нь төр өөрийнхөө өмч байгалийн баялгийг ашиглуулсны хариуд тухайн хувь хүн, хуулийн этгээдээс авч буй мөнгөн хөрөнгө


⁷ Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 23 дугаар зүйл

⁸ Засгийн Газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ийн 2.1

⁹ Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1

төгрөгийн хооронд, 2017-2018 онуудад 70-80 тэрбум төгрөгийн хооронд хэлбэлзэж байсан бол сүүлийн хоёр жил буюу 2019-2020 онуудад огцом өсөж 90-110 тэрбум төгрөгийн хооронд хэлбэлзэж 2013-2020 оны хооронд нийт 613.5 тэрбум төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлээд байна.

Зураг 9. 2013-2020 оны байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө болон гүйцэтгэл



Эх сурвалж: СЯ, Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан 2015-2020 он

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль болон “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ийн дагуу дараах 5 төрлийн орлогоор байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг бүрдүүлж¹⁰ байна.

- Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийн орлого;
- Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого;
- Ойн нөөц ашигласны төлбөрийн орлого;
- Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого;
- Газрын нөөцийн төлбөрийн орлого.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийг орлогын төрлөөр авч үзвэл 2013-2020 онуудад онуудад нийт 613.5 тэрбум төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн ба үүний 54.9 хувь ус, рашааны нөөц ашигласны төлбөр, 30.4 хувь газрын төлбөр, 7.5 хувь ойн нөөц ашигласны төлбөр, 4.3 хувь ан амьтны нөөц ашигласны төлбөр болон 1.8 хувь байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр тус тус эзэлж байна (Хүснэгт 5). Судалгааны үр дүнгээс харвал байгалийн нөөц ашигласны төлбөрийг орлогын дийлэнх буюу 90 орчим хувийг газрын төлбөр болон ус, рашааны нөөц ашигласны төлбөр эзэлж байна.

¹⁰ Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 13.2


Хүснэгт 5. 2013-2020 оны байгалийн нөөц ашигласны төлбөрийн биелэлт төвлөрсөн орлогын төрлөөр

										/сая төгрөг/
№	Байгалийн нөөц	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	Нийт
1	Ан амьтан	516.3	998.4	2,378.3	3,287.8	5,141.2	5,570.8	7,342.5	1,139.7	26,375.1
2	Ургамал	63.6	549.1	2,766.1	5,057.5	4,727.8	494.4	188.1	4,181.1	18,027.8
3	Газар	17,276.5	16,521.8	17,115.1	17,372.8	19,213.8	19,229.8	37,885.4	41,680.8	186,296.1
4	Ой	2,963.3	3,033.1	3,664.1	4,343.7	10,646.4	4,057.0	3,664.6	13,495.5	45,867.7
5	Ус	38,978.6	34,338.4	35,691.4	40,569.3	47,722.8	46,711.4	47,780.4	45,129.6	336,921.9
	Нийт	59,798.4	55,440.9	61,615.0	70,631.2	87,452.0	76,063.3	96,861.0	105,626.8	613,488.6

Эх сурвалж: СЯ, Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан 2013-2020 он

Ус ашигласны төлбөрийн хувьд томоохон ус ашиглагч аж ахуйн нэгжүүдэд 2016 онд 124.5 сая.м³/жил, 2017 онд 120.3 сая.м³/жил, 2018 онд 132.3 сая.м³/жил, 2019 онд 130.1 сая.м³/жил ус ашиглуулах дүгнэлт гаргаж, 2016 онд 40.6 тэрбум төгрөг, 2017 онд 47.7 тэрбум төгрөг, 2018 онд 46.7 тэрбум төгрөг, 2019 онд 47.8 тэрбум төгрөгийг (Хүснэгт 5) тус тус орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн.

Зураг 10. 2013-2020 оны байгалийн нөөц ашигласны төлбөрийн биелэлт төвлөрсөн орлогын төрлөөр




Эх сурвалж: СЯ, Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан 2013-2020 он

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг аймгийн төрлөөр авч үзвэл 2013-2020 онуудад нийт 613.5 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлсэн ба үүний 80 хувь буюу 490.2 тэрбум төгрөгийг Өмнөговь, Булган, Орхон, Төв, Сэлэнгэ, Дорнод гэсэн 6 аймгууд бүрдүүлсэн бол үлдсэн 20 хувь буюу 123.3 тэрбум төгрөгийн орлогыг бусад аймгууд бүрдүүлсэн байна. Орон нутгийн төсөвт 2013-2020 онуудад төвлөрүүлсэн байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын 54.9 хувь ус, рашааны нөөц ашигласны төлбөр, 30.4 хувь газрын төлбөр, 7.5 хувь ойн нөөц ашигласны төлбөр, 4.3 хувь ан амьтны нөөц ашигласны төлбөр болон 2.9 хувь байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр тус тус эзэлж байна. Хамгийн их байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого бүрдүүлсэн топ 5 аймгийн орлогыг

төрлөөр авч үзвэл Өмнөговь аймгийн орлогын 99 хувийг газрын төлбөр болон ус ашигласны төлбөр; Булган аймгийн орлогын 94 хувийг ус ашигласны төлбөр; Орхон аймгийн орлогын 98 хувийг газрын төлбөр; Төв аймгийн орлогын 79 хувийг газрын төлбөр болон ус ашигласны төлбөр, Сэлэнгэ аймгийн орлогын 48 хувийг ойн нөөц ашигласны төлбөр, 22 хувийг ус ашигласны төлбөр, 17 хувийг ургамлын нөөц ашигласны төлбөр тус тус эзэлж байна.

Зураг 11. 2013-2020 оны байгалийн нөөц ашигласны төлбөр аймгаар, орлогын төрлөөр



Эх сурвалж: СЯ, Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан 2013-2020 он

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлд тухайн байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос 15-85 хувийг байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулахаар заасан ба 2015-2020 онуудад орон нутгийн төсөвт нийт 498.2 тэрбум төгрөгийн байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого хуримтлагдсанаас хуулийн дагуу хамгийн багадаа 164.1 тэрбум төгрөгийг байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах шаардлагатай боловч 201.5 тэрбум төгрөгийг зарцуулсан боловч зарим аймгууд хуульд заасан төлбөрийн орлогын хувь, хэмжээний доод хязгаараар зарцуулаагүй байна (Хүснэгт 6).

Өмнөговь, Булган, Орхон, Төв, Сэлэнгэ, Дорнод, Өвөрхангай зэрэг өндөр орлого төвлөрүүлдэг аймгууд байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд хуульд заасан тухайн төсвийн жилд зарцуулах доод хязгаараас бага хэмжээгээр зарцуулсан байна.

Хүснэгт 6. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн дагуу 2015-2020 оны төвлөрүүлсэн орлого, зарлагын нэгтгэл

/сая төгрөг/


№	Үзүүлэлт	Төвлөрүүлсэн орлого	Хуулийн дагуу зарцуулах дүн	Зарцуулсан гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Архангай	12,371.6	3,569.3	7,200.4	3,631.2	202%
2	Баян-Өлгий	4,332.0	1,989.0	3,775.4	1,786.4	190%
3	Баянхонгор	6,804.8	2,434.1	4,059.6	1,625.4	167%
4	Булган	86,400.4	30,575.0	30,085.6	(489.4)	98%
5	Говь-Алтай	3,039.2	917.2	3,939.0	3,021.8	429%
6	Говь-Сүмбэр	4,055.9	1,263.9	2,665.7	1,401.8	211%
7	Дархан-Уул	8,522.5	2,089.7	3,215.1	1,125.4	154%
8	Дорноговь	7,302.2	1,690.2	2,626.9	936.7	155%
9	Дорнод	25,168.4	8,280.4	522.0	(7,758.4)	6%
10	Дундговь	3,114.8	1,055.1	2,003.3	948.2	190%
11	Завхан	5,704.5	2,451.4	5,818.5	3,367.2	237%
12	Орхон	75,629.5	11,705.7	1,465.1	(10,240.6)	13%
13	Өвөрхангай	8,579.7	4,386.6	3,586.5	(800.0)	82%
14	Өмнөговь	126,499.4	38,812.9	3,202.4	(35,610.5)	8%
15	Сүхбаатар	6,477.7	2,178.7	4,820.4	2,641.7	221%
16	Сэлэнгэ	26,166.2	14,434.8	8,175.0	(6,259.7)	57%
17	Төв	34,342.1	10,838.0	10,104.4	(733.6)	93%
18	Увс	4,586.2	1,781.0	5,966.2	4,185.2	335%
19	Улаанбаатар	19,027.3	6,780.1	74,821.9	68,041.8	1104%
20	Ховд	4,449.7	1,739.6	5,197.1	3,457.5	299%
21	Хөвсгөл	13,412.6	9,567.3	11,914.1	2,346.8	125%
22	Хэнтий	12,262.5	5,529.5	6,323.5	794.0	114%
	Нийт	498,249.4	164,069.4	201,488.4	37,419.0	123%

Манай улсын хувьд төрийн удирдлагын босоо тогтолцоо бий болоод нэлээд хугацаа өнгөрч орон нутгийн төр, захиргааны байгууллагууд иргэд, ард түмэнтэй улам ойр байж, тэдний санал хүсэлтийг мэдэрч, төрийн бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх боломж олгож байгаа билээ. Харин босоо тогтолцооны хэрэгжилтийн үндсэн механизм нь орон нутгийн төсөв. Сүүлийн жилүүдэд аймаг орон нутагт эрх мэдлийг шилжүүлэх, орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх талаар төр засгаас анхаарч нэлээд арга хэмжээ авсан хэдий ч Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт хангалттай түвшинд хүрэхгүй байсаар байна. Энэ нь засаглалын эрх мэдлийг орон нутагт түлхүү шилжүүлэх болон төсвийн харилцааг боловсронгуй болгох зорилтуудын хооронд нэлээд зөрүүтэй байгааг харуулж байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг аймгийн төрлөөр авч үзвэл 2020 оны жилийн эцэст орон нутгийн төсөвт төлөвлөгөөгөөр 101.5 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 105.6 тэрбум төгрөгийн орлого хуримтлагдаж 104.0 хувийн гүйцэтгэлтэй гарсан. Орон нутгийн төсөвт 2020 онд төвлөрүүлсэн байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын 42.7 хувь ус, рашааны нөөц ашигласны төлбөр, 39.5

хувь газрын төлбөр, 12.8 хувь ойн нөөц ашигласны төлбөр, 4 хувь байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр болон 1.1 хувь ан амьтны нөөц ашигласны төлбөр тус тус эзэлж байна.

Зураг 12. 2020 оны байгалийн нөөц ашигласны төлбөр аймгаар, орлогын төрлөөр



Эх сурвалж: СЯ, Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан 2020 он

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлд “тухайн байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос 15-85 хувийг байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулах хувь, хэмжээний доод хязгаараас дээш байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулна” гэж заасныг үндэслэн гүйцэтгэлийг дүгнэхэд орон нутгийн төсөвт 2020 онд төвлөрүүлсэн 105.6 тэрбум төгрөгийн байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос хуулийн дагуу хамгийн багадаа зарцуулбал зохих 34,715.7 сая төгрөгөөс байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд 50,406.5 сая төгрөг зарцуулсан боловч зарим аймгууд хуульд заасан төлбөрийн орлогын хувь, хэмжээний доод хязгаараар зарцуулаагүй байна (Хүснэгт 7).

Тухайлбал, байгалийн баялаг ихтэй, өндөр орлого төвлөрүүлдэг Өмнөговь, Орхон, Төв, Сэлэнгэ, Дорнод, Хөвсгөл, Хэнтий зэрэг аймгууд байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд хуульд заасан тухайн төсвийн жилд зарцуулах доод хязгаараас бага хэмжээгээр зарцуулсан байна.

Хүснэгт 7. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн дагуу 2020 оны төвлөрүүлсэн орлого, зарлагын нэгтгэл


/сая төгрөг/

№	Үзүүлэлт	Төвлөрүүлсэн орлого	Хуулийн дагуу зарцуулах дүн	Зарцуулсан гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Архангай	2,890.2	659.0	1,054.1	395.1	160%
2	Баян-Өлгий	381.0	164.1	629.8	465.6	384%
3	Баянхонгор	973.9	324.8	973.0	648.2	300%
4	Булган	14,959.4	5,194.2	5,286.6	92.4	102%
5	Говь-Алтай	533.7	122.2	832.4	710.2	681%
6	Говь-Сүмбэр	638.8	172.4	433.5	261.1	251%
7	Дархан-Уул	1,810.0	397.7	504.1	106.5	127%
8	Дорноговь	2,759.3	524.1	615.1	91.0	117%
9	Дорнод	4,821.3	1,574.9	522.0	(1,052.9)	33%
10	Дундговь	635.3	179.4	484.0	304.5	270%
11	Завхан	1,142.2	464.0	1,123.8	659.8	242%
12	Орхон	19,817.7	3,052.3	306.9	(2,745.4)	10%
13	Өвөрхангай	1,360.2	579.7	688.8	109.1	119%
14	Өмнөговь	24,058.5	6,871.8	845.4	(6,026.4)	12%
15	Сүхбаатар	981.3	247.1	1,464.3	1,217.2	593%
16	Сэлэнгэ	8,403.0	5,002.4	1,562.1	(3,440.3)	31%
17	Төв	7,790.6	3,168.4	1,642.7	(1,525.8)	52%
18	Увс	988.6	212.5	1,193.5	980.9	562%
19	Улаанбаатар	3,632.1	1,289.0	25,725.3	24,436.3	1996%
20	Ховд	344.7	86.5	1,620.5	1,534.0	1873%
21	Хөвсгөл	3,335.4	2,540.0	1,670.5	(869.6)	66%
22	Хэнтий	3,369.6	1,888.8	1,228.0	(660.8)	65%
	Нийт	105,626.8	34,715.7	50,406.5	15,690.8	145%

Аймаг, нийслэлийн Засаг дарга болон Байгаль орчны асуудал хариуцсан байгууллагын удирдлагууд байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд хуульд заасан зарцуулах доод хязгаараас дээш хэмжээгээр зориулалтын дагуу зарцуулах, зарцуулалтай холбоотой зориулалт бус ашиглалтын зөрчлийг бууруулж, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах нь зүйтэй.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль болон “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын хэрэгжилтийн шинжилгээний үр дүнг эрх бүхий байгууллагад танилцуулж, холбогдох шийдвэрийг гарган Байгаль орчин аялал жуулчлалын сайдтай аймаг, нийслэлийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээнд тусган, засаглалын шат бүрд эрх мэдлийг оновчтой хуваарилан, хариуцлагын тогтолцоог сайжруулан хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах шаардлагатай.

Зураг 13. 2020 оны аймаг, нийслэлийн Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт



Орон нутгийн хүрээлэн буй орчны хөтөлбөрийн төсөв зохиох, гүйцэтгэлийг тайлагнах талаар орон нутгийн иргэдийн хурал болон Засаг дарга нарын хариуцлагыг дээшлүүлэх, улсын болон орон нутгийн төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлд тавих санхүүгийн хяналтын одоогийн тогтолцоог шинэчлэн сайжруулж холбогдох хууль, эрх зүйн нэгдсэн зохицуулалт хийж төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийн биелэлтэд тавих явцын хяналтыг хэрэгжүүлэх шаардлагатай.


Засаглалын шат бүрд эрх мэдлийг оновчтой хуваарилах, хариуцлага тооцох, аймаг орон нутгийн тогтвортой хөгжлийг хангах, бүс нутгийг жигд хөгжүүлэх, төсвийн тогтвортой байдлыг дунд хугацаанд тогтвортой байлгах зэрэг асуудал нь эцсийн дүнд улсын болон орон нутгийн төсвийн харилцаа ямар түвшинд байгаагаас шууд шалтгаална. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг төсөвт төвлөрүүлэх, дахин хуваарилах процесс, улсын болон орон нутгийн төсөв хоорондын харилцааг боловсронгуй болгох, байгалийн нөөц ашиглалтын хяналт, мониторингийн зохистой тогтолцоог бий болгох замаар хуулийн хэрэгжилтийг хангах шаардлагатай.

ОРОН НУТГИЙН ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧНЫ ХӨТӨЛБӨРИЙН ЗАРЛАГЫН ШИНЖИЛГЭЭ

БОАЖЯ-ны 2020 оны үйл ажиллагаандаа баримтлах бодлого нь хүрээлэн буй орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх үүргээ биелүүлж байгаа хариуцлагатай уул уурхайг дэмжих, агаар, орчны бохирдлыг бууруулах, хүн амын эрүүл, аюулгүй байдлыг орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, аялал жуулчлалыг эдийн засгийн тэргүүлэх салбарын нэг болгон хөгжүүлэх, байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг зориулалтын дагуу зарцуулахад хяналт тавих, байгаль орчинд ээлтэй дэвшилтэт технологийг нэвтрүүлэх үйл ажиллагааг дэмжихэд оршино.

Монгол улсад үр дүнд суурилсан төсвийн төлөвлөлт, төсвийн дунд хугацааны зарлагын хүрээг нэвтрүүлэх ажлыг 2021 оноос туршилтын журмаар эхлүүлээд байна. Төсөв, санхүүгийн удирдлагыг сайжруулах, улсын төсвийн зарлагын үр ашиг, үр нөлөөг дээшлүүлэхэд төсвийн зарлагын шинжилгээ чухал үүрэг гүйцэтгэж байна. Энэхүү шинжилгээ нь орон нутгийн төсөв, санхүүгийн тогтолцооны талаар сүүлийн үеийн үнэн зөв мэдээлэл өгч, төсвийн зорилтот үр дүнг хангах, нэгдсэн төсвийн сахилга бат, хөрөнгийн эх үүсвэрийн стратеги хуваарилалт болон төрийн үйлчилгээг үр ашигтай хүргэхэд дэмжлэг үзүүлнэ.

Зураг 14. Орон нутгийн төсөвт эзлэх байгаль орчны зардал, эзлэх хувь



Эх сурвалж: СЯ, Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан 2020 он, Төсвийн сарын гүйцэтгэлийн мэдээ 2020 он

Дээрх зургаас харахад орон нутгийн нийт төсөв болон хүрээлэн буй орчин хөтөлбөрт зарцуулсан гүйцэтгэл харилцан адилгүй байна. Орон нутгийн 10 аймаг нь хүрээлэн буй орчин хөтөлбөрт 1 тэрбум төгрөгөөс дээш дүн зарцуулсан бол үлдсэн 11 аймаг хүрээлэн буй орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд 1 тэрбум төгрөгөөс доош дүн зарцуулсан байна.

Зураг 15-т үзүүлснээр аймаг, нийслэлийн байгаль орчны зардлын тухайн орон нутгийн нийт төсөвт эзлэх хувийг тооцоолоход Булган аймаг 2020 онд хамгийн их буюу 5.6 тэрбум төгрөг төлөвлөж, 5.3 тэрбум төгрөг зарцуулсан нь аймгийн нийт төсвийн 8.2 хувийг эзэлж байна. Бусад аймгийн орон нутгийн төсөвт байгаль орчны зардлын эзлэх хувь 2020 онд 0.23-2.32 хүртэл хувийг эзэлж, дунджаар орон нутгийн төсвийн 1.24 хувийг хүрээлэн буй орчин хөтөлбөрт зарцуулсан байна. Харин байгалийн баялаг ихтэй Өмнөговь, Орхон аймгуудын нийт төсөвт эзлэх байгаль орчны зардал хамгийн бага үзүүлэлттэй буюу 0.42 хувь, 0.23 хувь байгааг харж болно.

Зураг 15. Байгаль орчны зардлын орон нутгийн төсөвт эзлэх хувь



Сангийн сайдын 2015 оны 7 дугаар тушаалаар баталсан төсвийн зарлагын хөтөлбөрийн ангиллаар Хүрээлэн буй орчин дараах хөтөлбөрүүдээс бүрдэж байна. Үүнд:

Зураг 16. Сангийн сайдын 2015 оны 7-р тушаалаар баталсан Төсвийн зарлагын хөтөлбөрийн¹¹ ангилал

71400	Хүрээлэн буй орчин
71401	Хог хаягдал
71402	Биологийн төрөл зүйлийн хамгаалалт

¹¹ Төсвийн тухай хуулийн 4.1.16. “хөтөлбөр” гэж төсөв хуваарилах зорилгоор үр дүнг нь тооцож, тайлагнаж болохуйц өөр хоорондоо үялдаа бүхий төрийн чиг үүргийг хангахад чиглэсэн багц арга хэмжээг

71403	Ойжуулалт
71404	Усны нөөц, нуур, гол мөрний менежмент
71405	Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалт
71406	Хүрээлэн буй орчны бохирдол, доройтол
71407	Агаарын бохирдлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлт
71408	Ус цаг уур, орчны шинжилгээ
71409	Нэн ховор, ховордсон амьтан, ургамлын хамгаалалт
71410	Газрын доройтлыг бууруулах, цөлжилтөөс сэргийлэх
71411	Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага
71412	Хүрээлэн буй орчны судалгаа шинжилгээ
71413	Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх

Сангийн сайдын 7 дугаар тушаалаар баталсан төсвийн зарлагын хөтөлбөрийн ангилал 2015 оноос хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор, орон нутгийн хүрээлэн буй орчны хөтөлбөрийн шинжилгээг орон нутгийн байгаль орчны 2015-2020 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан, төсвийн сарын гүйцэтгэлийн мэдээ болон аудитлагдсан санхүүгийн тайлан дээр үндэслэн өнгөрсөн хугацааны хандлага болон өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлж, орон нутгийн төсөв, санхүүгийн удирдлагын талаар сүүлийн үеийн бодитой шинжилгээний мэдээллээр хангах зорилгоор хийж гүйцэтгэсэн.

Хүрээлэн буй орчин хөтөлбөрүүдийн 2015-2020 оны гүйцэтгэлийг Хүснэгт 8-д үзүүлэв. Байгаль орчны орон нутгийн төсвийн зардал сүүлийн 6 жилд дунджаар 29,640.8 сая төгрөг байгаа бөгөөд 2015 онд хамгийн бага буюу 19,892.8 сая төгрөг, 2020 онд хамгийн их буюу 50,406.5 сая төгрөг байв.

Хүснэгт 8. Байгаль орчны орон нутгийн төсвийн байгууллагын хүрээлэн буй орчин хөтөлбөрийн 2015-2020 оны гүйцэтгэл /сая төгрөг/

Хөтөлбөр	2015	2016	2017	2018	2019	2020	Нийт
Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр	532.6	532.2	637.1	1,054.7	5,317.7	17,442.3	25,516.6
Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх				1,907.4	6,510.3	11,268.2	19,685.8
Биологийн төрөл зүйлийн хамгаалалт	501.8	784.4	1,540.4	978.0	18.5		3,823.2
Нэн ховор, ховордсон амьтан, ургамлын хамгаалалт	254.3	293.8	281.0	281.8	273.7		1,384.7
Ойжуулалт	1,951.4	1,034.8	1,172.8	1,391.3	2,122.5	2,689.0	10,361.7
Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалт			34.7	34.7			69.3
Ус цаг уур, орчны шинжилгээ			30.0		43.5	30.0	103.5
Усны нөөц, нуур, гол мөрний менежмент	87.5						87.5
Хог хаягдал	5,154.3	6,900.9	7,807.1		572.6	813.8	21,248.8
Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага	9,359.3	15,189.8	11,932.8	16,249.3	17,785.4	17,727.8	88,244.4
Хүрээлэн буй орчны бохирдол, доройтол	2,051.7	1,060.5	1,830.6	1,746.3	195.2	435.4	7,319.6
Нийт	19,892.8	25,796.5	25,266.4	23,643.5	32,839.3	50,406.5	177,844.9

Эх сурвалж: СЯ, Нэгдсэн төсвийн гүйцэтгэл 2015-2020 он, Төсвийн сарын гүйцэтгэлийн мэдээ 2015-2020 он

Төсвийг эдийн засгийн ангиллаар урсгал зардал, хөрөнгийн зардал, эргэн төлөгдөх цэвэр зээл гэж ангилдаг. Байгаль орчны орон нутгийн төсийн зарлагыг эдийн засгийн ангилалаар авч үзвэл 2020 оны байдлаар нийт зарлага 50,406.5 сая төгрөг ба үүний 50,396.7 сая төгрөг буюу 99.98 хувийг урсгал зардал, 9.8 сая төгрөг буюу 0.02 хувийг хөрөнгийн зардал түс түс эзэлж байна (Зураг 17).

Зураг 17. Байгаль орчны орон нутгийн 2020 оны хөтөлбөр болон эдийн засгийн ангилал



Эх сурвалж: СЯ, Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан 2020 он, Төсвийн сарын гүйцэтгэлийн мэдээ 2020 он

Хүснэгт 9. Байгаль орчны орон нутгийн 2020 оны хөтөлбөрийн төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая төгрөг/

№	Хөтөлбөр	2020			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт	Зөрүү
1	Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр	33,493.7	17,442.3	52.1%	16,051.4
2	Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх	12,378.3	11,268.2	91.0%	1,110.1
3	Биологийн төрөл зүйлийн хамгаалалт				-
4	Нэн ховор, ховордсон амьтан, ургамлын хамгаалалт				-
5	Ойжуулалт	2,907.7	2,689.0	92.5%	218.6
6	Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалт				-
7	Ус цаг уур, орчны шинжилгээ	30.0	30.0	100.0%	-
8	Усны нөөц, нуур, гол мөрний менежмент				-
9	Хог хаягдал	854.8	813.8	95.2%	41.0
10	Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага	19,259.3	17,727.8	92.0%	1,531.4
11	Хүрээлэн буй орчны бохирдол, доройтол	528.1	435.4	82.4%	92.7
Нийт		69,451.9	50,406.5	72.6%	19,045.3

Эх сурвалж: СЯ, Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан 2020 он, Төсвийн сарын гүйцэтгэлийн мэдээ 2020 он

Байгаль орчны орон нутгийн 2020 оны хөтөлбөрийн гүйцэтгэлийг Зураг 18-аас харахад 2020 оны байдлаар нийт санхүүжилтийн 34.6 хувийг Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр, 35.2 хувийг Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага, 22.4 хувийг Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх хөтөлбөр эзэлж байна. Эдгээр 3 төрлийн хөтөлбөр нийт байгаль орчны орон нутгийн зардлын 92.1 хувийг эзэлж байгаа бол үлдсэн 7.9 хувийг Ойжуулалт, Хог хаягдал, Ус цаг уур, орчны шинжилгээ, Хүрээлэн буй орчны бохирдол, доройтол хөтөлбөр эзэлж байна.

Зураг 18. Байгаль орчны орон нутгийн 2020 оны хөтөлбөрийн гүйцэтгэл



Эх сурвалж: СЯ, Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан 2020 он, Төсвийн сарын гүйцэтгэлийн мэдээ 2020 он

Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр

Улаанбаатар хотын хүн ам өдрөөс өдөрт өсөн нэмэгдэж, хотын экологийн асуудал хэт их ачаалал, дарамт, стресст орж байна. Төлөвлөлтгүй, эмх замбараагүй суурьшил бий болсноос үүдэн агаар бохирдуулах эх үүсвэрийн тоо жил бүр өсөн нэмэгдэж, агаарын бохирдлоос шалтгаалсан амьсгалын замын өвчлөлийн эрсдэл улам ихсэж, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөл бүрдэхгүй байгааг олон арван судалгааны дүн илтгэж байна.

Агаарын бохирдлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлт хөтөлбөр нь 2015-2017 онуудад жил бүр дунджаар 500.0-600.0 сая төгрөг зарцуулж байсан бол нийслэл хот болон бусад суурин газруудад үүсээд байгаа агаар, орчны бохирдлыг бууруулахад чиглэсэн цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэн хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 98 дугаар тогтоолоор Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийг батлуулсан. Улмаар агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрт зарцуулах санхүүжилт жил бүр огцом өсөж 2018 онд 1.1 тэрбум, 2019 онд 5.3 тэрбум, 2020 онд 17.4 тэрбум төгрөгийг тус тус орон нутгийн төсвөөс зарцуулсан (Зураг 19).

Хот төлөвлөлтийг боловсронгуй болгож, төвлөрлийг сааруулан, дэд бүтцийн байгууламжийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэн бохирдлын эх үүсвэрийг багасгаж, хүн амд амьдрах орчны зөв дадлыг төлөвшүүлэх замаар агаар, орчны бохирдлыг бууруулж эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэх зорилгоор 2020 онд 33.4 тэрбум төгрөг төлөвлөж, өнгөрсөн оноос 3.3 дахин их буюу 17.4 тэрбум төгрөг зарцуулан, 52 хувийн биелэлттэй гарсан.

Зураг 19. Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн 2015-2020 оны гүйцэтгэл



Эх сурвалж: СЯ, Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан 2015-2020 он

Хүсэгт 10-т харуулсанаар Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрт 2020 онд нийслэл хот болон Ховд аймагт гүйцэтгэл гарсан. Улаанбаатар хотын хувьд Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрт Агаарын чанарын алба 32.2 тэрбум төгрөг төлөвлөж, 16.1 тэрбум төгрөг зарцуулсан, Гэр хорооллын хөгжлийн газар 628.9 сая төгрөг төлөвлөж, 607.3 сая төгрөг

зарцуулсан байна. Харин 21 аймгуудаас зөвхөн Ховд аймаг Засаг даргын тамгын газар байгууллагаар тус хөтөлбөрт 700 сая төгрөг зарцуулсан гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 10. Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн 2020 оны төлөвлөгөө, гүйцэтгэл аймаг, нийслэлээр болон байгууллагаар

	/сая төгрөг/	
Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Улаанбаатар	32,793.7	16,742.3
Агаарын чанарын алба	32,164.8	16,135.0
Гэр хорооллын хөгжлийн газар	628.9	607.3
Ховд	700.0	700.0
Засаг даргын тамгын газар	700.0	700.0
Нийт дүн	33,493.7	17,442.3

Эх сурвалж: СЯ, Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан 2020 он, Төсвийн сарын гүйцэтгэлийн мэдээ 2020 он

Улаанбаатар хот

Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэсэн.

- 2016 онд нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд орших 2 тарифт тоолууртай гэр хорооллын айл өрхийн шөнийн цахилгааны хэрэглээг 100 хувиар хөнгөлөх, 21 аймгийн төв болон 10 мянгаас дээш хүн амтай сүм, суурин газрын гэр хорооллын бүс дэх хоёр тарифт тоолууртай өрхийн 21.00-06.00 цагийн хооронд хэрэглэсэн цахилгааныг 50 хувиар хөнгөлсөн.
- Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах зорилгоор гэр хорооллын 41,964 айл өрхийг цахилгаан халаагуураар халаах түгээх сүлжээний техникийн боломжийг бүрдүүлэх барилга угсралтын ажлыг 2017-2019 онд хоёр үе шаттайгаар хэрэгжүүлж дуусгав.
- 2017 онд гэр хорооллын дулааны шугам сүлжээний хүчин чадлыг нэмэгдүүлэх, зураг төсөл нь бэлэн болсон 68 халаалтын зуухыг буулгаж, хэрэглэгчийг төвлөрсөн системд холбосон.
- Нийслэлийн 2018 оны төсвийн 10.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Чингэлтэй дүүргийн 7 дугаар хорооны “Бичил дэд төв”-ийн ус, дулаан хангамж, нам даралтын халаалтын зуух, авто зам, гадна тохижилт, гэрэлтүүлгийн ажлууд хийгдэж, 2019 оны 10 дугаар сарын 12-ны өдөр ашиглалтад оруулсан.
- Нийслэлийн төвийн 6 дүүрэгт 2019 оны 5 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн түүхий нүүрс хэрэглэхийг хориглохоор шийдвэрлэсэн. “Таван толгой түлш” ХХК-ийг байгуулж, жилд 200.000 тонны хүчин чадалтай 4 үйлдвэрийн 8 шугамыг ашиглалтад оруулсан. Сургууль, цэцэрлэг зэрэг орон байрны доторх агаарын бохирдлыг бууруулахаар 91 цэцэрлэг, 21 сургуулийн бага анги, 11 эмнэлгийн хүүхдийн тасаг, эрчимт эмчилгээний тасагт нийт 1,300 агаар шүүгч төхөөрөмж олгосон.

Ховд аймаг

Ховд хотын агаарын бохирдлын хэмжээг бууруулах зорилгоор гэр хорооллын 500 өрхөд түлшний хэмнэлттэй керамик доторлогоотой 500 ширхэг зуухнуудыг айл өрхүүдэд хийж өгсөн нь Жаргалант сумын хэмжээнд түүхий нүүрсний хэрэглээг 1,700 орчим тонноор бууруулсан. Монгол гэрийн дулаалгыг 450 өрхөд хөнгөлөлттэй үнээр борлуулсан нь үр дүнтэй ажил болсон ба өрх бүр 1-2 тонн түүхий нүүрс хэмнэж 700 орчим тонн түүхий нүүрсийг шатаагаагүй байна. Мөн гэр хорооллын хувийн сууц болон Монгол гэртэй нийт 106 айлд цахилгаан халаагуурыг суурилуулсан ба эдгээр өрхүүд түүхий нүүрсний хэрэглээгээ 50-100 хувь бууруулсан. Гэр хорооллын бүсэд орон сууцжуулах ажлыг

эрчимжүүлэх зорилгоор хаус хороолол, таун хаус барих төслүүдэд 300.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг “Бат дайчин” ХХК, “Алтан-Орд констракшн” ХХК-уудад олгосон.

Хүснэгт 11. Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн 2020 оны төлөвлөгөө, гүйцэтгэл аймаг, нийслэлээр, байгууллагаар болон эдийн засгийн ангиллаар

/сая төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр	33,493.7	17,442.3
Улаанбаатар	32,793.7	16,742.3
Агаарын чанарын алба	32,164.8	16,135.0
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	32,164.8	16,135.0
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	32,164.8	16,135.0
УРСГАЛ ЗАРДАЛ	32,164.8	16,135.0
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	32,093.2	16,063.8
ТАТААС	66.6	66.6
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5.0	4.6
Гэр хорооллын хөгжлийн газар	628.9	607.3
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	628.9	607.3
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	628.9	607.3
УРСГАЛ ЗАРДАЛ	628.9	607.3
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	623.9	602.3
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5.0	5.0
Ховд	700.0	700.0
Засаг даргын тамгын газар	700.0	700.0
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	700.0	700.0
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	700.0	700.0
УРСГАЛ ЗАРДАЛ	700.0	700.0
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	700.0	700.0

Эх сурвалж: СЯ, Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан 2020 он, Төсвийн сарын гүйцэтгэлийн мэдээ 2020 он

Орон нутгийн 2020 оны төсвийн гүйцэтгэлээр агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрт 33.5 тэрбум төгрөг төлөвлөж, 17.4 тэрбум төгрөг зарцуулж, 52 хувийн биелэлттэй гарсан. Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн санхүүжилтийг 100 хувь урсгал зардалд зарцуулсан ба үүний 92.3 хувь буюу 16.1 тэрбум төгрөгийг агаарын бохирдлыг бууруулах, 7.0 хувь буюу 1.2 тэрбум төгрөгийг үндсэн үйл ажиллагаа, үлдсэн хэсэг нь агаарын чанарыг сайжруулахад олгох татаас, мэдээлэл, сурталчилгаа, харуул, хамгаалалтын арга хэмжээнд тус тус зарцуулагдсан байна (Зураг 20).

Зураг 20. Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн 2020 оны эдийн засгийн ангилал, арга хэмжээний ангилал



Эх сурвалж: СЯ, Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан 2020 он, Төсвийн сарын гүйцэтгэлийн мэдээ 2020 он

Хүснэгт 12. Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн 2020 оны арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, хувь


Хөтөлбөр, зориулалт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр	33,493.7	17,442.3	52.1%
Агаарын бохирдлыг бууруулах	31,940.2	16,094.0	50.4%
Агаарын чанарыг сайжруулахад олгох татаас	66.6	66.6	100.0%
Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	10.0	9.6	95.6%
Мэдээлэл, сурталчилгааны зардал	26.0	26.0	100.0%
Үндсэн үйл ажиллагааны зардал	1,422.0	1,218.6	85.7%
Харуул, хамгаалалтын зардал	28.8	27.5	95.4%

Эх сурвалж: СЯ, Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан 2020 он, Төсвийн сарын гүйцэтгэлийн мэдээ 2020 он

Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх

Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх хөтөлбөрт 2015-2017 онуудад гүйцэтгэл гараагүй бөгөөд 2018-2020 онуудад нийт 21.4 тэрбум төгрөг төлөвлөж, 19.7 тэрбум төгрөг зарцуулж, 92 хувийн гүйцэтгэлтэй гарсан. Орон нутгийн төсвөөс жил бүр байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх хөтөлбөрт зарцуулах дүнг өсөн нэмэгдүүлж 2018 онд 2.0 тэрбум, 2019 онд 7.0 тэрбум, 2020 онд 12.4 тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөсөн байна (Зураг 21).

Зураг 21. Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх хөтөлбөрийн 2015-2020 оны төлөвлөгөө, гүйцэтгэл



Эх сурвалж: СЯ, Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан 2015-2020 он

Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх хөтөлбөрийн зарцуулалтыг орон нутагт харилцан адилгүй, өөр өөр байгууллагад төлөвлөж, зарцуулж байна. Улаанбаатар хотын хувьд Байгаль, орчин ногоон хөгжлийн газар болон Үндэсний цэцэрлэгт хүрээлэн гэсэн хоёр байгууллагаар зарцуулсан бол аймгууд Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Байгаль хамгаалах сан болон Засаг даргын тамгын газар гэсэн дараах гурван байгууллагаар 2020 онд зарцуулсан байна. Тухайлбал, Дорнод, Хэнтий аймгууд байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардлыг Байгаль орчин, аялал жуулчлалын газар болон Байгаль хамгаалах сан гэсэн хоёр байгууллагаар зарцуулсан бол Дорноговь, Өвөрхангай, Хөвсгөл аймгууд Байгаль орчин, аялал жуулчлалын газар болон Засаг даргын тамгын газар гэсэн хоёр байгууллагаар зарцуулсан байна. Ховд аймаг зөвхөн Засаг даргын тамгын газар байгууллагаар, Увс аймаг зөвхөн Байгаль хамгаалах сангаар зарцуулдаг бол Баянхонгор, Булган, Дархан-Уул, Дундговь, Сэлэнгэ зэрэг аймгууд зөвхөн Байгаль орчин, аялал жуулчлалын газар байгууллагаар байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардлыг зарцуулж байна (Хүснэгт 13).

Хүснэгт 13. Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх хөтөлбөрийн 2020 оны төлөвлөгөө, гүйцэтгэл байгууллагаар болон аймгаар

	/сая төгрөг/	
Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх	12,378.3	11,268.2
Байгаль орчин, аялал жуулчлалын газар	6,821.7	6,293.4
Баянхонгор	923.7	906.6
Булган	538.0	528.2
Дархан-Уул	628.9	453.7
Дорноговь	711.5	573.8
Дорнод	452.3	426.8
Дундговь	438.8	429.5
Өвөрхангай	383.6	383.7

Сэлэнгэ	1,272.3	1,238.1
Хөвсгөл	516.2	400.2
Хэнтий	956.5	952.8
Байгаль хамгаалах сан	828.2	500.4
Говьсүмбэр	3.2	3.2
Дорнод	20.5	1.0
Увс	484.9	413.4
Хэнтий	319.5	82.7
Засаг даргын тамгын газар	1,056.4	873.5
Дорноговь	41.3	41.3
Өвөрхангай	266.1	231.1
Ховд	404.9	404.8
Хөвсгөл	344.2	196.3
Байгаль, орчин ногоон хөгжлийн газар	1,482.0	1,413.6
Улаанбаатар	1,482.0	1,413.6
Үндэсний цэцэрлэгт хүрээлэн	2,190.1	2,187.3
Улаанбаатар	2,190.1	2,187.3

Эх сурвалж: СЯ, Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан 2020 он, Төсвийн сарын гүйцэтгэлийн мэдээ 2020 он

Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх хөтөлбөрийг аймаг, нийслэлд харилцан адилгүй, өөр өөр байгууллагад төлөвлөж, зарцуулж байгаа нь төсөв санхүүгийн хяналтыг сулруулах, үр ашиггүй зардал гаргах эрсдэлтэй тул санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон салбарын яамнаас төсвийн удирдлагыг үр ашигтай зохион байгуулж, санхүүгийн сахилга батыг сайжруулах зорилгоор нэгдсэн удирдамж, заавраар хангах нь зүйтэй.

Мөн зарим аймгууд Засаг даргын тамгын газар байгууллагаар төлөвлөж, зарцуулах бус орон нутгийн байгаль орчин, аялал жуулчлалын үндсэн чиглэлийн байгууллагад нь төлөвлөж, зарцуулах нь зүйтэй.

Орон нутгийн 2020 оны төсвийн гүйцэтгэлээр байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх хөтөлбөрт 12,378.3 сая төгрөг төлөвлөж, 11,268.2 сая төгрөг зарцуулж, 91 хувийн биелэлттэй гарсан. Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх санхүүжилтийг 100 хувь урсгал зардалд зарцуулсан ба үүний 64.8 хувь буюу 7,305.5 сая төгрөгийг байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, 33.4 хувь буюу 3,768.2 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагаа, үлдсэн хэсэг нь ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг, хүр хог хаягдал, орчны бохирдлыг устгах, цэвэрлэх үйлчилгээ болон харуул, хамгаалалтын арга хэмжээнд тус тус зарцуулагдсан байна (Зураг 22).

Зураг 22. Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх хөтөлбөрийн 2020 оны эдийн засгийн ангилал, арга хэмжээний ангилал



Эх сурвалж: СЯ, Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан 2020 он, Төсвийн сарын гүйцэтгэлийн мэдээ 2020 он

Хүснэгт 14. Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх хөтөлбөрийн 2020 оны арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, хувь


Хөтөлбөр, зориулалт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх	12,378.3	11,268.2	91.0%
Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	154.0	147.3	95.6%
Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх	8,264.5	7,305.5	88.4%
Мэдээлэл, сурталчилгааны зардал	0.4	0.4	97.8%
Үндсэн үйл ажиллагааны зардал	3,911.6	3,768.2	96.3%
Харуул, хамгаалалтын зардал	6.5	5.6	85.7%
Хур хог хаягдал, орчны бохирдлыг устгах, цэвэрлэх үйлчилгээ	41.3	41.3	100.0%

Эх сурвалж: СЯ, Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан 2020 он, Төсвийн сарын гүйцэтгэлийн мэдээ 2020 он

Биологийн төрөл зүйлийн хамгаалалт

Биологийн төрөл зүйлийн хамгаалалт хөтөлбөрт 2015-2019 оны хооронд нийт 4.7 тэрбум төгрөг төлөвлөж, 3.8 тэрбум төгрөг зарцуулж, 81 хувийн биелэлттэй гарсан ба 2020 онд гүйцэтгэл гараагүй.

Зураг 23. Биологийн төрөл зүйлийн хамгаалалт хөтөлбөрийн 2015-2020 оны төлөвлөгөө, гүйцэтгэл



Эх сурвалж: СЯ, Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан 2015-2020 он

Биологийн төрөл зүйлийн хамгаалалт хөтөлбөрийн зарцуулалтыг орон нутагт харилцан адилгүй, өөр өөр байгууллагад төлөвлөж, зарцуулж байна. Хөвсгөл аймгийн бүх сумд Засаг даргын тамгын газар байгууллагаар биологийн төрөл зүйлийн хамгаалалт хөтөлбөрийн зардлыг орон нутгийн төсвийн эх үүсвэрээр байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээд 2015-2019 онуудад түүштай санхүүжүүлж байгаа бол зарим аймгууд зөвхөн нэг жил тухайн хөтөлбөрт зардал гарган тайлагнаж байна (Хүснэгт 17, 18). Тухайлбал, Булган аймаг Засаг даргын тамгын газар байгууллагаар зөвхөн 2015 онд ургамал хамгаалал арга хэмжээнд 12.0 сая төгрөг төлөвлөж, 10.6 тэрбум төгрөг зарцуулж, 88 хувийн гүйцэтгэлтэй гарсан (Хүснэгт 15) бол Говьсүмбэр аймаг Байгаль хамгаалах сангаар 2016-2017 онуудад байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээд нийт 30.6 сая төгрөг зарцуулсан байна (Хүснэгт 16).

Хүснэгт 15. Биологийн төрөл зүйлийн хамгаалалт хөтөлбөрийн 2015 оны төлөвлөгөө, гүйцэтгэл хөтөлбөр, арга хэмжээ болон аймгаар

	/сая төгрөг/		
Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
Биологийн төрөл зүйлийн хамгаалалт	829.7	501.8	60.5%
Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх	817.7	491.3	60.1%
Хөвсгөл	817.7	491.3	60.1%
Ургамал хамгаалал	12.0	10.6	88.0%
Булган	12.0	10.6	88.0%

Эх сурвалж: СЯ, Нэгдсэн төсвийн гүйцэтгэл 2015 он, Төсвийн сарын гүйцэтгэлийн мэдээ 2015 он

Хүснэгт 16. Биологийн төрөл зүйлийн хамгаалалт хөтөлбөрийн 2016-2017 оны гүйцэтгэл хөтөлбөр, арга хэмжээ болон аймгаар

	/сая төгрөг/	
Үзүүлэлт	2016 он	2017 он
Биологийн төрөл зүйлийн хамгаалалт	784.4	1,540.4

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх	784.4	1,540.4
Говьсүмбэр	14.3	16.3
Хөвсгөл	770.1	1,524.1

Эх сурвалж: СЯ, Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан 2016-2017 он

Хүснэгт 17. Биологийн төрөл зүйлийн хамгаалалт хөтөлбөрийн 2018 оны төлөвлөгөө, гүйцэтгэл хөтөлбөр, арга хэмжээ, аймаг болон байгууллагаар

	/сая төгрөг/	
Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Биологийн төрөл зүйлийн хамгаалалт	1,151.0	978.0
Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх	1,151.0	978.0
Хөвсгөл	1,151.0	978.0
Хө. Алаг-Эрдэнэ. Засаг даргын тамгын газар	14.9	14.9
Хө. Арбулаг. Засаг даргын тамгын газар	9.7	9.7
Хө. Байгаль орчны газар	796.9	686.6
Хө. Баянзүрх. Засаг даргын тамгын газар	17.6	17.6
Хө. Бүрэнтогтох. Засаг даргын тамгын газар	16.9	13.9
Хө. Галт. Засаг даргын тамгын газар	19.4	8.0
Хө. Жаргалант. Засаг даргын тамгын газар	16.7	11.3
Хө. Их-Уул. Засаг даргын тамгын газар	14.3	12.3
Хө. Мөрөн. Засаг даргын тамгын газар	4.6	4.6
Хө. Рашаант. Засаг даргын тамгын газар	11.8	9.0
Хө. Ренчинлхүмбэ. Засаг даргын тамгын газар	26.7	16.2
Хө. Тариалан. Засаг даргын тамгын газар	24.8	15.0
Хө. Тосонцэнгэл. Засаг даргын тамгын газар	10.3	10.3
Хө. Төмөрбулаг. Засаг даргын тамгын газар	13.2	13.2
Хө. Түнэл. Засаг даргын тамгын газар	18.4	17.2
Хө. Улаан-Уул. Засаг даргын тамгын газар	15.3	15.3
Хө. Ханх. Засаг даргын тамгын газар	11.3	11.3
Хө. Хатгал. Засаг даргын тамгын газар	17.2	17.2
Хө. Цагааннуур. Засаг даргын тамгын газар	7.3	2.3
Хө. Цагаан-Уул. Засаг даргын тамгын газар	16.1	10.6
Хө. Цагаан-Үүр. Засаг даргын тамгын газар	10.1	8.0
Хө. Цэцэрлэг. Засаг даргын тамгын газар	11.9	9.3
Хө. Чандмань-Өндөр. Засаг даргын тамгын газар	11.8	11.7
Хө. Шинэ-Идэр. Засаг даргын тамгын газар	7.3	6.8
Хө. Эрдэнэбулган. Засаг даргын тамгын газар	26.6	25.6

Эх сурвалж: СЯ, Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан 2018 он, Төсвийн сарын гүйцэтгэлийн мэдээ 2018 он

Хүснэгт 18. Биологийн төрөл зүйлийн хамгаалалт хөтөлбөрийн 2019 оны төлөвлөгөө, гүйцэтгэл аймаг, хөтөлбөр, арга хэмжээ болон эдийн засгийн ангиллаар

	/сая төгрөг/	
Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл


Хөвсгөл	1,151.0	978.0
Биологийн төрөл зүйлийн хамгаалал	1,151.0	978.0
Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх	1,151.0	978.0
УРСГАЛ ЗАРДАЛ	1,151.0	978.0
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,151.0	978.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээ төлбөр	1,151.0	978.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,151.0	978.0
Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,151.0	978.0

Эх сурвалж: СЯ, Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан 2019 он, Төсвийн сарын гүйцэтгэлийн мэдээ 2019 он

Нэн ховор, ховордсон амьтан, ургамлын хамгаалалт

Нэн ховор, ховордсон амьтан, ургамлын хамгаалах хөтөлбөрт 2015-2019 оны хооронд нийт 1.6 тэрбум төгрөг төлөвлөж, 1.4 тэрбум төгрөг зарцуулж, 89 хувийн биелэлттэй гарсан ба 2020 онд гүйцэтгэл гараагүй (Зураг 24). Орон нутгийн төсвөөс тус хөтөлбөрт 2015-2020 онуудад жил бүр дунджаар 300.0 орчим сая төгрөг төлөвлөж, зарцуулж байсан бол энэхүү зардал нь байгаль орчны орон нутгийн нийт зардлын дөнгөж 1 хувьд хүрэхгүй байна.

Зураг 24. Нэн ховор, ховордсон амьтан, ургамлын хамгаалалт хөтөлбөрийн 2015-2020 оны төлөвлөгөө, гүйцэтгэл



Эх сурвалж: СЯ, Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан 2015-2020 он

Улаанбаатар хотын Минж нутагшуулах баг үржүүлгийн төв орчимд цүнхээл үүсгэн минж нутагшуулж, тоо толгойг олшруулах, байгальд дасгах нөхцөл бүрдүүлэн, усны урсцыг нэмэн нөөцийг арвижуулах, экологийн боловсролын тогтолцоонд арга зүйн туслалцаа үзүүлэх эко түр болгон хөгжүүлэх зорилгоор нэн ховор, ховордсон амьтан, ургамлын хамгаалах хөтөлбөрт 2015-2018 оны хооронд нийт 1.2 тэрбум төгрөг төлөвлөж, 1.1 тэрбум төгрөг зарцуулж, 92 хувийн биелэлттэй гарсан (Хүснэгт 19). Нэн ховор, ховордсон амьтан, ургамлын хамгаалах хөтөлбөрийн санхүүжилтийг урсгал зардалд зарцуулсан ба үүний 97.8 хувь буюу 1,086.1 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагаа, 1.2 хувь буюу 13.3

сая төгрөгийг гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ, үлдсэн хэсэг нь ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал болон мал эмнэлгийн үйлчилгээ арга хэмжээнд тус тус зарцуулагдсан байна.

Хүснэгт 19. Нэн ховор, ховордсон амьтан, ургамлын хамгаалалт хөтөлбөрийн 2015-2018 оны гүйцэтгэл нийслэл, байгууллага, хөтөлбөр болон арга хэмжээгээр

/сая төгрөг/				
Үзүүлэлт	2015	2016	2017	2018
Улаанбаатар	254.3	293.8	281.0	281.8
Минж нутагшуулах баг	254.3	293.8	281.0	281.8
Нэн ховор, ховордсон амьтан, ургамлын хамгаалалт	254.3	293.8	281.0	281.8
Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал		4.3	1.4	1.0
Үндсэн үйл ажиллагааны зардал	238.5	289.5	277.2	280.8
Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	13.3			
Мал эмнэлгийн үйлчилгээ	2.5			
Үр дүнгийн урамшуулал			2.4	

Эх сурвалж: СЯ, Нэгдсэн төсвийн гүйцэтгэл 2015-2018 он, Төсвийн гүйцэтгэлийн мэдээ 2015-2018 он

Минж нь усны түвшин багассан үед голын эрэгт суваг татах, далан барих зэргээр орчноо намагжуулах, орчны чийгшлийг нэмэхэд гол үүрэгтэй мэрэгч амьтан. “Минж нутагшуулах, үржүүлэх төслийн нэгж” ОНӨҮГ-ыг 2012 онд Баянзүрх дүүргийн 20 дугаар хороо, Гачууртын төвөөс 7 км орчим газарт Туул голын экосистемийг байгалийн аясаар нэмэгдүүлэх, сайжруулахаар байгуулсан ба 2019 оноос Нийслэлийн Байгаль орчны газарт харьяалагдах болсон. Туул голын эх болон түүний цутгал болох Заан, Тэрэлж голуудад 2012 оноос хойш нийт 57 бодгаль минжийг нутагшуулаад байна.

Нийслэлийн 2019 оны төсвийн гүйцэтгэлийн тайланд Байгаль хамгаалах сан байгууллага нэн ховор, ховордсон амьтан, ургамлын хамгаалах хөтөлбөрт 341.2 сая төгрөг төлөвлөж, 273.7 сая төгрөг зарцуулж, 80 хувийн биелэлттэй гарсан. Хөтөлбөрийн санхүүжилтийг урсгал зардалд зарцуулсан ба үүний 272.7 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагаа буюу ажилтны цалин хөлс, байр ашиглалтын зардалд, 1.0 сая төгрөгийг ажил олгогчоос олгох тэтгэмжид тус тус зарцуулсан байна (Хүснэгт 20, 21).

Хүснэгт 20. Нэн ховор, ховордсон амьтан, ургамлын хамгаалах хөтөлбөрийн 2019 оны төлөвлөгөө, гүйцэтгэл нийслэл, байгууллага, хөтөлбөр болон арга хэмжээгээр

/сая төгрөг/			
Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
Улаанбаатар	341.2	273.7	80.2%
Байгаль хамгаалах сан	341.2	273.7	80.2%
Нэн ховор, ховордсон амьтан, ургамлын хамгаалалт	341.2	273.7	80.2%
Үндсэн үйл ажиллагааны зардал	340.2	272.7	80.1%
Ажил олгогчоос олгох тэтгэмж	1.0	1.0	100.0%

Эх сурвалж: СЯ, Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан 2019 он, Төсвийн сарын гүйцэтгэлийн мэдээ 2019 он

Хүснэгт 21. Нэн ховор, ховордсон амьтан, ургамлын хамгаалалт хөтөлбөрийн 2019 оны төлөвлөгөө, гүйцэтгэл нийслэл, байгууллага, хөтөлбөр, арга хэмжээ болон эдийн засгийн ангиллаар

/сая төгрөг/		
Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл

Улаанбаатар	341.2	273.7
Байгаль хамгаалах сан	341.2	273.7
Нэн ховор, ховордсон амьтан, ургамлын хамгаалалт	341.2	273.7
Үндсэн үйл ажиллагааны зардал	340.2	272.7
УРСГАЛ ЗАРДАЛ	340.2	272.7
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	340.2	272.7
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	112.6	74.4
Ажил олгогчоос төлөх НДШ	14.1	8.4
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27.6	11.5
Хангамж, бараа материалын зардал	5.7	4.3
Нормативт зардал	127.3	127.3
Эд хогшил, урсгал засварын зардал	38.0	35.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын төлбөр	14.6	11.3
Бараа үйлчилгээний бусад зардал	0.5	0.5
Ажил олгогчоос олгох тэтгэмж,	1.0	1.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1.0	1.0

Эх сурвалж: СЯ, Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан 2019 он, Төсвийн сарын гүйцэтгэлийн мэдээ 2019 он


Ойжуулалт

Төрөөс ойн талаар баримтлах бодлогын “Монгол орны экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах, ойн нөөцийн хомсдол, доройтлыг зогсоох, ойг нөхөн сэргээх, ойжуулах замаар ойгоор бүрхэгдсэн талбайг нэмэгдүүлэх, зүй зохистой, тогтвортой ашиглахад чиглэсэн ойн тогтвортой менежментийг бий болгох” гэсэн зорилгыг хэрэгжүүлэхэд баримтлах зарчмын хүрээнд Монгол орны ойг хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглах чиглэлээр үндэсний хэмжээнд тэргүүлэх 5 зорилтыг тодорхойлон ажиллаж байна.

Ойн сангийн талбай 18,582.7 мян.га буюу нийт нутаг дэвсгэрийн 11.8 хувийг эзлэх ба үүний 12,392.8 мян.га нь ойгоор бүрхэгдсэн буюу ойрхог чанар 7.9 хувь байна. Нийт ойн сангийн 1,703.9 мян.га нь ойн түймэрт, 116.6 мян.га хөнөөлт шавжид, 0.9 мян.га нь байгалийн гамшиг салхи шүүрга, цасанд нэрвэгдсэний, 109.1 мян.га нь мод бэлтгэл явагдсаны улмаас доройтолд орсон байна. 2018 оны төлөв байдлын үзүүлэлтийг 2015-2016 оны төлөв байдлын үзүүлэлттэй харьцуулахад нийт талбай 133.6 мян.га-аар, нөөц 7.1 сая м³-р нэмэгдэж, сүүлийн жилүүдэд ойрхог чанарын эзлэх хувь тогтвортой хадгалагдаж байна.

Орон нутгийн төсвөөс ойжуулалтын санхүүжилтэд 2015-2020 онуудад харьцангуй тогтмол буюу жилд дунджаар 1.0-3.0 тэрбум төгрөг төлөвлөж, зарцуулж байсан ба энэхүү зардал нь байгаль орчны орон нутгийн зардлын дөнгөж 4-6 хувийг эзэлж байна. Ойжуулалтын хөтөлбөрт 2015-2018 онуудад жилд дунджаар 1.0 тэрбум гаруй төгрөг зарцуулж байсан бол 2019-2020 онуудад жилд дунджаар 2.0 тэрбум гаруй төгрөг зарцуулсан (Зураг 25).

Зураг 25. Байгаль орчны орон нутгийн нийт зардал болон ойжуулалт хөтөлбөрийн 2015-2020 оны гүйцэтгэл, эзлэх хувь



Эх сурвалж: СЯ, Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан 2015-2020 он

Ойжуулалт хөтөлбөрийг орон нутагт ижил зарчмаар аймгийн Ойн анги байгууллагад төлөвлөж, зарцуулж байна. Улсын хэмжээнд 2016-2019 онд улсын төсвийн 6.9 тэрбум, орон нутгийн төсвийн 1.6 тэрбум, аж ахуйн нэгж, байгууллагын 1.3 тэрбум төгрөгийн санхүүжилтээр ойжуулалтын ажил 10685.9 га, байгалийн сэргэн ургалтад туслах ажил 8,310.4 га-д хийж, 2,482.7 га-д ойн зурвас байгуулж, ой нөхөн сэргээх ажлыг нийт 21,479 га талбайд хийсэн. Нийт 9,210.5 га талбайд улсын төсвийн хөрөнгөөр, 4,459.7 га талбайд орон нутгийн төсвийн хөрөнгөөр, 7,825.2 га аж ахуйн нэгж, төслийн хөрөнгөөр ойжуулалтын ажлыг тус тус гүйцэтгэсэн.

Хүснэгт 22. Ойжуулалт хөтөлбөрийн 2020 оны төлөвлөгөө, гүйцэтгэл байгууллага болон аймгаар /сая төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Ойжуулалт	2,907.7	2,689.0
Ойн анги	2,907.7	2,689.0
Архангай	167.7	166.4
Баян-Өлгий	63.2	59.9
Баянхонгор	69.8	66.4
Булган	178.7	163.0
Говь-Алтай	267.2	226.7
Говьсүмбэр	114.7	114.0
Дархан-Уул	51.3	50.4
Дорнод	59.8	59.5
Дундговь	58.2	54.5
Завхан	134.8	128.1
Орхон	106.7	94.5
Өвөрхангай	82.6	74.1

Өмнөговь	444.5	390.5
Сүхбаатар	66.6	66.6
Сэлэнгэ	324.2	294.0
Төв	135.2	127.5
Увс	157.1	149.8
Ховд	57.1	54.2
Хөвсгөл	159.6	156.5
Хэнтий	208.7	192.5

Эх сурвалж: СЯ, Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан 2020 он, Төсвийн сарын гүйцэтгэлийн мэдээ 2020 он

Дээрх хүснэгтээс харахад 2020 оны орон нутгийн төсвийн гүйцэтгэлээр ойжуулалтад 2,907.7 сая төгрөг төлөвлөж, 2,689.0 сая төгрөг зарцуулж, 92 хувийн гүйцэтгэлтэй гарсан. Ойжуулалтын санхүүжилтийг 100 хувь урсгал зардалд зарцуулсан ба үүний 81.8 хувь буюу 2,199.8 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагаа, 8.6 хувь буюу 232.1 сая төгрөгийг ойжуулалт, 7.4 хувь буюу 199.6 сая төгрөгийг байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үлдсэн хэсэг нь ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг, гэрээт ажиллагсад болон харуул, хамгаалалтын арга хэмжээнд тус тус зарцуулагдсан байна.

Дархан-Уул

Сум дундын ойн анги байгууллагын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 3 зорилтын хүрээнд 23 арга хэмжээг хэрэгжүүлж, ойжуулалтад 51.3 сая төгрөг төлөвлөж, 50.4 сая төгрөг зарцуулж, 98.2 хувийн гүйцэтгэлтэй ажилласан. Ойжуулалт, нөхөн сэргээлтийн ажлын хүрээнд орон нутгийн төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх 21 га талбайд навчит модны ойжуулалт, 9 га талбайд ойн зурвас хийх талбайг сонгон зураглал гарган ажлын явцад технологийн хяналт тавьж ажилласан. Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, ухуулга сурталчилгааг нийт 585 км газар нутгийг хамарсан 37 малчин өрх айл, иргэд, 5 ойн мэргэжлийн байгууллага, 56 ойн нөхөрлөлтэй уулзаж 3 төрлийн сэрэмжлүүлгийн материал, 1 албан мэдэгдэл олгож заавар зөвлөгөө өгсөн байна. Мөн ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор 64 нөхөрлөл, 30 морин эргүүлтэй хамтран ажилласны дүнд ой, хээрийн түймэр гараагүй байна. Аймгийн хэмжээнд 4 ойн мэргэжлийн байгууллага, 3 ойн нөхөрлөл 1193 м.куб хэрэглээний модны эрхийн бичиг, 4 сумын 631 өрхөд 2521 м.куб түлээний эрхийн бичиг олгож ойн нөөц ашигласны төлбөр болох 21.4 сая төгрөгийг ойн нөөц ашигласны төлбөрийн орлогын дансанд төвлөрүүлсэн.

Архангай

Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр ойжуулалтын ажлыг 6 сумдын 190 га талбайд, байгалийн сэргэн ургалтад туслах ажлыг 6 сумын 270 га талбайд ойн мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж ажлын явцын хяналтыг тавин ажиллаж, 30 га талбайд ойн зурвас байгуулсан. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр ойжуулалтын ажлыг 91 га, байгалийн сэргэн ургалтад туслах ажлыг 130 талбайд томоохон голын эх Цэнхэр, Булган, Жаргалант сумдын ойн санд Ойд хангай, Модлог ургамлын цэцэрлэг, Номин хангайн төгөл ХХК-аар гүйцэтгүүлж ажлын гүйцэтгэлд хяналт тавьж заавар зөвлөмж өгч ажилласан. Цөлжилтөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Урд Тамирын голын эрэг дагуу улиасны 1,500 гаруй мөчрөөр ойжуулалтын ажлыг хийж усалгаа, арчилгааны ажлыг байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлийн гишүүдээр гүйцэтгүүлсэн. Ойн мэргэжлийн байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагууд ойжуулалт, ойн арга хэмжээг хэрэгжүүлэхэд нийт 250 гаруй иргэнийг түр ажлыг байраар ханган ажилласан байна.

Ойжуулалтын санхүүжилтийг 100 хувь урсгал зардалд зарцуулсан бөгөөд үүний дийлэнх 81.8 хувь буюу 2,199.8 сая төгрөг үндсэн үйл ажиллагаанд зарцуулагдсан бол ердөө 8.6 хувь буюу 232.1 сая төгрөгийг ойжуулалт, 7.4 хувь буюу 199.6 сая төгрөгийг байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулсан нь хангалтгүй тул орон нутгийн төсвийн захирагчид ойжуулалтын үйл ажиллагаанд зарцуулах төсвийг нэмэгдүүлэх нь зүйтэй.

Зураг 26. Ойжуулалт хөтөлбөрийн 2020 оны эдийн засгийн ангилал, арга хэмжээний ангилал



Эх сурвалж: СЯ, Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан 2020 он, Төсвийн сарын гүйцэтгэлийн мэдээ 2020 он

Хүснэгт 23. Ойжуулалт хөтөлбөрийн 2020 оны арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, гүйцэтгэлийн хувь

Хөтөлбөр, зориулалт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
Ойжуулалт	2,907.7	2,689.0	92.5%
Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	46.8	45.4	96.9%
Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх	236.5	199.6	84.4%
Гэрээт ажиллагсдын зардал	8.5	6.9	81.4%
Мэдээлэл, сурталчилгааны зардал	0.5	-	0.0%
Ойжуулалт	235.1	232.1	98.7%
Үндсэн үйл ажиллагааны зардал	2,374.8	2,199.8	92.6%
Харуул, хамгаалалтын зардал	5.5	5.3	96.5%


Эх сурвалж: СЯ, Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан 2020 он, Төсвийн сарын гүйцэтгэлийн мэдээ 2020 он

Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалт

Монгол улс тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг жилээс жилд нэмэгдүүлэн 2016 оны байдлаар нийт нутаг дэвсгэрийнхээ 17.4 хувийг буюу 28 сая гаруй га талбайг улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамруулжээ. Улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газрын нийт талбайн хэмжээ 44.3 сая га-д хүрч, нийт нутаг дэвсгэрийн 28.3 хувийг эзэлж байна.

(З.Батжаргал, Шийрэвдамба 2016). Засгийн газрын 2017 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн 91 дүгээр тогтоолоор Тост, Тосон бумбын нурууны байгалийн нөөц газрын хилийн цэсийг 743,058.00 га талбайгаар, Ноён уулын байгалийн нөөц газрыг 11,187.05 га, Ноён уулын дурсгалт газрыг 650.0 га талбайгаар хилийн заагийг тогтоосон. Улмаар 3 аймгийн 3 сумын 754,895.05 га буюу нийт газар нутгийн 0.44 хувийг улсын тусгай хамгаалалтад авч, нийт газар нутгийн 17.85 хувьд хүрсэн. Мөн Засгийн газрын 2019 оны 8 дугаар сарын 14-ны өдрийн 319 дүгээр тогтоолоор Тост, Тосон бумбын нурууны байгалийн нөөц газрыг 153,482.37 га-аар өргөтгөн нийт 896,540.37 га талбайгаар хилийн заагийг тогтоож, улсын тусгай хамгаалалтад авсан. УИХ-ын 2019 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн хуралдаанаар 22 газрыг Улсын тусгай хамгаалалтад нэмж авснаар Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн тоо 117 болж улсын газар нутгийн 20.1 хувь буюу нийт 31,449,994 га талбайг хамарч байна. Мөн цэнгэг усны нөөц, томоохон гол мөрний урсац бүрэлдэх эхийн 48.4 хувь, ойн сан бүхий газрын 39.3 хувийг хамгаалалтад авсан байна. 1992 оноос өнөөг хүртэлх хугацаанд тусгай хамгаалалттай газар нутгийн талаарх төрийн бодлого, хэрэгжүүлж буй үйл ажиллагааны үр дүнд байгуулсан тусгай хамгаалалттай газар нутаг, түүний сүлжээ нь биологийн олон янз байдал, экосистемийн хамгаалалд тодорхой үүрэг гүйцэтгэж байна.

Зураг 27. Монгол улсын тусгай хамгаалалттай газар нутаг




Дорноговь аймгийн Байгаль орчны алба 2017-2018 онуудад Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалт хөтөлбөрийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд жил бүр 34.7 сая төгрөг төлөвлөж, орон нутгийн төсвийн эх үүсвэрээс бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрт нийт 69.3 сая төгрөгөөр зарцуулж, 100 хувийн гүйцэтгэлтэй гарсан (Зураг 28).

Төсвийн тухай хуулиар орон нутгийн төсвөөр хэрэгжүүлэх байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх чиг үүргийг зааж өгсөн. Иймд улсын төсвөөс байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зориулалтаар орон нутагт зөвхөн ус цаг уур, орчны шинжилгээний газар, тусгай хамгаалалттай газар нутгийн болон

сав газрын захиргаа байгууллагуудын санхүүжилтийг олгож байна. Гэвч орон нутгийн Засаг даргын тамгын газар байгууллага чиг үүргийг давхцуулан Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалт хөтөлбөрийг төлөвлөж, зарцуулж байгааг залруулах нь зүйтэй.

Зураг 28. Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалт хөтөлбөрийн 2015-2020 оны төлөвлөгөө, гүйцэтгэл



Эх сурвалж: СЯ, Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан 2015-2020 он

Хүснэгт 24. Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалт хөтөлбөрийн 2017 болон 2018 оны төлөвлөгөө, гүйцэтгэл аймаг, байгууллага, хөтөлбөр, арга хэмжээ болон эдийн засгийн ангиллаар /сая төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Дорноговь	34.7	34.7
Байгаль орчны алба	34.7	34.7
Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалал	34.7	34.7
Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх	34.7	34.7
УРСГАЛ ЗАРДАЛ	34.7	34.7
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	34.7	34.7
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	34.7	34.7
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	34.7	34.7
Орон нутгийн төсвөөс санхүүжих	34.7	34.7

Эх сурвалж: СЯ, Нэгдсэн төсвийн гүйцэтгэл 2017-2018 он, Төсвийн сарын гүйцэтгэлийн мэдээ 2017-2018 он


Ус цаг уур, орчны шинжилгээ

БОАЖЯ-ны харьяа Цаг уур, орчны шинжилгээний газар нь ус, цаг агаар, байгаль орчны төлөв байдалд байнгын хяналт шинжилгээ хийж, бодит болон урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллээр нийгмийн хэрэгцээг шуурхай хангах, байгалийн болзошгүй гамшгийн эрсдэлээс сэрэмжлүүлэх

зорилготой Монгол Улсын Засгийн газрын агентлаг юм. Цаг уур, орчны шинжилгээний газрын харьяа орон нутагт аймаг, хотын Ус, цаг уур, орчны шинжилгээний төв гэсэн улсын төсвийн байгууллагуудтай бөгөөд эдгээр босоо тогтолцоотой байгууллагуудын үйл ажиллагааны орлого улсын төсөвт төвлөрдөг.

Ус цаг уур, орчны шинжилгээ хөтөлбөрт 2015-2020 оны хооронд нийт 105.0 сая төгрөг төлөвлөж, 103.5 сая төгрөг зарцуулсан ба үүний 30.0 сая төгрөгийг 2017 онд, 43.5 сая төгрөгийг 2019 онд, үлдсэн 30.0 сая төгрөгийг 2020 онд тус тус зарцуулсан байна (Зураг 29). Орон нутгийн төсвийн байгууллагуудаас зөвхөн Сэлэнгэ аймаг энэхүү 103.5 сая төгрөгийн санхүүжилтийг Засаг даргын тамгын газар байгууллагад төлөвлөж, зарцуулсан.

Зураг 29. Ус цаг уур, орчны шинжилгээ хөтөлбөрийн 2015-2020 оны төлөвлөгөө, гүйцэтгэл



Эх сурвалж: СЯ, Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан 2015-2020 он

Орон нутгийн 2020 оны төсвийн гүйцэтгэлээр ус цаг уур, орчны шинжилгээ хөтөлбөрт 30.0 тэрбум төгрөг төлөвлөж, 30.0 тэрбум төгрөг зарцуулж, 100 хувийн биелэлттэй гарсан (Хүснэгт 25). Сэлэнгэ аймгийн Засаг даргын тамгын газар байгууллага 2017-2020 онуудад нийт 103.5 сая төгрөгийн санхүүжилтийг орон нутгийн төсвөөс цаг агаарт зориудаар нөлөөлж үүл бүүдаж, бороо оруулах зорилгоор зарцуулж, ус цаг уур, орчны шинжилгээ хөтөлбөрт ангилан тайлагнасан.

Хүснэгт 25. Ус цаг уур, орчны шинжилгээ хөтөлбөрийн 2020 оны төлөвлөгөө, гүйцэтгэл аймаг, байгууллага, хөтөлбөр болон арга хэмжээгээр

Үзүүлэлт	/сая төгрөг/		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
Сэлэнгэ	30.0	30.0	100.0%
Засаг даргын тамгын газар	30.0	30.0	100.0%
Ус цаг уур, орчны шинжилгээ	30.0	30.0	100.0%
Ус цаг уурын судалгаа, шинжилгээ	30.0	30.0	100.0%

Эх сурвалж: СЯ, Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан 2020 он, Төсвийн сарын гүйцэтгэлийн мэдээ 2020 он


Төсвийн тухай хуулиар орон нутгийн төсвөөр хэрэгжүүлэх байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх чиг үүргийг зааж өгсөн. Иймд улсын төсвөөс байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зориулалтаар орон нутагт зөвхөн ус цаг уур, орчны шинжилгээний газар, тусгай хамгаалалттай газар нутгийн болон сав газрын захиргаа байгууллагуудын санхүүжилтийг олгож байна. Гэвч орон нутгийн Засаг даргын тамгын газар байгууллага чиг үүргийг давхцуулан ус цаг уур, орчны шинжилгээ хөтөлбөрийг төлөвлөж, зарцуулж байгааг залруулах нь зүйтэй.

Усны нөөц, нуур, гол мөрний менежмент

Усны нөөцийн нэгдсэн менежмент нь экосистемийн тэнцвэрт байдлыг алдагдуулахгүйгээр эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэхийн тулд ус болон газар, тэдгээртэй холбоотой нөөцийн нэгдсэн менежментийг сайжруулах үйл явц. Орон нутагт усны нөөц, нуур, гол мөрний менежмент хөтөлбөрт зөвхөн 2015 онд 94.0 сая төгрөг төлөвлөж, 87.5 сая төгрөг зарцуулж, 93 хувийн биелэлттэй гарсан ба үүнээс хойших 2016-2020 онуудад гүйцэтгэл гараагүй байна (Зураг 30).

Хэрлэн, Увс нуур-Тэс, Ерөө, Сэлэнгэ, Буйр нуур-Халх гол, Онги голын сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг 2016 онд, Хараа, Шишхэд, Хүйсийн говь-Цэцэг нуурын сав газрын төлөвлөгөөг 2018 онд, Алтайн өвөр говь, Умард говийн гүвээт-Халхын дундад тал, Галба-Өөш, Долоодын говь, Орог нуур-Түйн гол, мэнэнгийн тал, Чулуут, Үенч-Бодонч, Буулган голын сав газрын төлөвлөгөөг 2019 онд тус тус батлуулсан.

Зураг 30. Усны нөөц, нуур, гол мөрний менежмент хөтөлбөрийн 2015-2020 оны төлөвлөгөө, гүйцэтгэл



Эх сурвалж: СЯ, Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан 2015-2020 он

Булган аймгийн Засаг даргын тамгын газар байгууллага зөвхөн 2015 онд усны нөөц, нуур, гол мөрний менежмент хөтөлбөрийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд 94.0 сая төгрөг төлөвлөж, орон нутгийн төсвийн эх үүсвэрээр 87.5 тэрбум төгрөгөөр хөрөнгө худалдан авч, 93 хувийн гүйцэтгэлтэй гарсан (Хүснэгт 26).

Хүснэгт 26. Усны нөөц, нуур, гол мөрний менежмент хөтөлбөрийн 2015 оны төлөвлөгөө, гүйцэтгэл аймаг, байгууллага, хөтөлбөр, арга хэмжээ болон эдийн засгийн ангиллаар

/сая төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Булган	94.0	87.5
Засаг даргын тамгын газар	94.0	87.5
Усны нөөц, нуур, гол мөрний менежмент	94.0	87.5
Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх	94.0	87.5
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	94.0	87.5
Бусад хөрөнгө	94.0	87.5
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	94.0	87.5
Орон нутгийн төсвөөс санхүүжих	94.0	87.5

Эх сурвалж: СЯ, Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан 2015 он, Төсвийн сарын гүйцэтгэлийн мэдээ 2015 он

Хог хаягдал

Хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, хог хаягдлын зохистой менежментийн тогтолцоог бүрдүүлэх, хувийн хэвшил, орон нутгийн оролцоог сайжруулах зорилгоор хог хаягдлын хөтөлбөрт 2015-2020 оны хооронд нийт 22.9 тэрбум төгрөг төлөвлөж, 21.2 тэрбум төгрөг зарцуулж, 92 хувийн гүйцэтгэлтэй гарсан. Хог хаягдлын хөтөлбөрт 2015-2017 онуудад сүүлийн жилүүдтэй харьцуулахад харьцангуй өндөр жилд дунджаар 6.6 тэрбум гаруй төгрөг зарцуулж байсан.

Хог хаягдлын цогц менежментийг бий болгон, түүнийг дэмжих эдийн засгийн хөшүүргийг бүрдүүлэх, хаягдлыг дахин боловсруулах, дахин ашиглах, түүнээс эрчим хүч үйлдвэрлэх замаар хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулж байгалийн нөөц баялгийг хэмнэх, устгах, хог хаягдлын хэмжээг бууруулах, тогтвортой хөгжлийн бодлоготой үялдуулж, олон улсад тавигддаг шаардлагатай нийцүүлэн “Хог хаягдлын тухай хууль”-ийг боловсруулж, 2017 оны 5 сараас мөрдүүлж эхэлсэн.

2018 онд гүйцэтгэл гараагүй бөгөөд 2019-2020 онуудад орон нутгаас хог хаягдал зарцуулах санхүүжилт огцом буурч жилд дунджаар 500.0-900.0 сая төгрөгийн хооронд зарцуулсан байна.


Хүснэгт 27. Хог хаягдлын хөтөлбөрийн 2019 оны төлөвлөгөө, гүйцэтгэл аймаг, байгууллага, хөтөлбөр болон арга хэмжээгээр

/сая төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
Сүхбаатар аймаг	642.8	572.6	89.1%
Тохижилт үйлчилгээ	642.8	572.6	89.1%
Хог хаягдал	642.8	572.6	89.1%
Нийтийн эзэмшлийн гудамж талбайн гэрэлтүүлэг	162.0	162.0	100.0%
Хур хог хаягдал, орчны бохирдлыг устгах, цэвэрлэх үйлчилгээ	480.8	410.6	85.4%

Эх сурвалж: СЯ, Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан 2019 он, Төсвийн сарын гүйцэтгэлийн мэдээ 2019 он

Зураг 31. Хог хаягдлын хөтөлбөрийн 2015-2020 оны төлөвлөгөө, гүйцэтгэл



Эх сурвалж: СЯ, Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан 2015-2020 он

Орон нутгийн төсвийн байгууллагуудаас 2020 онд зөвхөн Сүхбаатар аймгийн Баруун урт-Хот тохижуулах газар хог хаягдлын хөтөлбөрт 854.8 сая төгрөг төлөвлөж, 813.8 сая төгрөг зарцуулж, 95.2 хувийн биелэлттэй гарсан. Нийт санхүүжилтийн 297.0 сая төгрөгийг нийтийн эзэмшлийн гудамж талбайн гэрэлтүүлэгт зарцуулсан бол 516.8 сая төгрөгийг хур хог хаягдал, орчны бохирдлыг устгах, цэвэрлэх үйлчилгээнд тус тус зарцуулсан (Хүснэгт 28). Бусад аймаг, нийслэлийн хувьд орон нутгийн төсвөөс хог хаягдлын хөтөлбөрт гүйцэтгэл гарсан боловч Сангийн сайдын 2015 оны 7 тоот тушаалын хөтөлбөр, зориулалтын дагуу төсвийн төлөвлөгөөг төлөвлөхгүйгээс тухайн хөтөлбөрт гүйцэтгэл тайлагнагдахгүй байх тохиолдол гарч байна.

Хүснэгт 28. Хог хаягдлын хөтөлбөрийн 2020 оны төлөвлөгөө, гүйцэтгэл аймаг, байгууллага, хөтөлбөр болон арга хэмжээгээр

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
Сүхбаатар	854.8	813.8	95.2%
Баруун урт-Хот тохижуулах газар	854.8	813.8	95.2%
Хог хаягдал	854.8	813.8	95.2%
Нийтийн эзэмшлийн гудамж талбайн гэрэлтүүлэг	297.0	297.0	100.0%
Хур хог хаягдал, орчны бохирдлыг устгах, цэвэрлэх үйлчилгээ	557.8	516.8	92.7%

Эх сурвалж: СЯ, Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан 2020 он, Төсвийн сарын гүйцэтгэлийн мэдээ 2020 он

Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага

Орон нутгийн төсвөөс хүрээлэн буй орчны бодлого, удирдлага хөтөлбөрийн санхүүжилтэд 2015-2020 онуудад нийт 97,136.9 тэрбум төгрөг төлөвлөж, 88,244.4 тэрбум төгрөг зарцуулж, 91 хувийн гүйцэтгэлтэй гарсан. Байгаль орчны орон нутгийн нийт зардлын дийлэнх буюу 50 гаруй хувийг 2015-2020 онуудад тус хөтөлбөрт зарцуулж ирсэн ба 2018 онд хамгийн өндөр буюу байгаль

орчны орон нутгийн нийт зардлын 69 хувь нь хүрээлэн буй орчны бодлого, удирдлага хөтөлбөрт зарцуулагдсан байна (Зураг 32).

Зураг 32. Байгаль орчны орон нутгийн зардал болон хүрээлэн буй орчны бодлого, удирдлага хөтөлбөрийн 2015-2020 оны гүйцэтгэл



Эх сурвалж: СЯ, Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан 2015-2020 он

Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага хөтөлбөрийн зарцуулалтыг орон нутагт харилцан адилгүй, өөр өөр байгууллагад төлөвлөж, зарцуулж байна. Улаанбаатар хотын хувьд Байгаль, орчин ногоон хөгжлийн газар, Үндэсний цэцэрлэгт хүрээлэн болон Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын газар гэсэн гурван байгууллагаар зарцуулсан бол аймгууд Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Байгаль хамгаалах сан болон Засаг даргын тамгын газар гэсэн дараах гурван байгууллагаар 2020 онд зарцуулсан байна. Тухайлбал, Бүлган аймаг хүрээлэн буй орчны бодлого, удирдлага хөтөлбөрийн зардлыг Байгаль хамгаалах сан болон Засаг даргын тамгын газар гэсэн хоёр байгууллагаар зарцуулсан бол Төв аймаг Байгаль орчин, аялал жуулчлалын газар болон Засаг даргын тамгын газар гэсэн хоёр байгууллагаар зарцуулсан байна. Орхон аймаг зөвхөн Байгаль хамгаалах сангаар зарцуулдаг бол бусад аймгууд зөвхөн Байгаль орчин, аялал жуулчлалын газар байгууллагаар хүрээлэн буй орчны бодлого, удирдлага хөтөлбөрийн зардлыг зарцуулж байна.

Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага хөтөлбөрийг аймаг, нийслэлд харилцан адилгүй, өөр өөр байгууллагад төлөвлөж, зарцуулж байгаа нь төсөв санхүүгийн хяналтыг сулруулах, үр ашиггүй зардал гаргах эрсдэлтэй тул санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон салбарын яамнаас төсвийн удирдлагыг үр ашигтай зохион байгуулж, санхүүгийн сахилга батыг сайжруулах зорилгоор нэгдсэн удирдамж, заавраар хангах нь зүйтэй. Мөн зарим аймгууд Засаг даргын тамгын газар байгууллагаар төлөвлөж, зарцуулах бус орон нутгийн байгаль орчин, аялал жуулчлалын үндсэн чиг үүргийн байгууллагад нь төлөвлөж, зарцуулах нь зүйтэй.

Хүснэгт 29. Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага хөтөлбөрийн 2020 оны төлөвлөгөө, гүйцэтгэл байгууллага болон аймгаар

/сая төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага	19,259.3	17,727.8
Байгаль орчин, аялал жуулчлалын газар	7,019.6	6,909.5
Архангай	894.0	887.7
Баян-Өлгий	510.0	504.6
Говь-Алтай	629.7	605.7
Говьсүмбэр	341.7	316.3
Завхан	995.7	995.7
Өмнөговь	468.6	454.9
Сүхбаатар	600.7	583.9
Төв	555.8	551.5
Увс	642.2	630.3
Ховд	461.6	461.5
Хөвсгөл	919.8	917.4
Байгаль хамгаалах сан	226.3	215.1
Булган	6.5	2.7
Орхон	219.8	212.4
Засаг даргын тамгын газар	6,083.7	5,556.4
Булган	4,882.9	4,592.7
Төв	1,200.8	963.7
Байгаль, орчин ногоон хөгжлийн газар	1,546.7	1,408.6
Улаанбаатар	1,546.7	1,408.6
Үндэсний цэцэрлэгт хүрээлэн	1,947.0	1,852.7
Улаанбаатар	1,947.0	1,852.7
Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын газар	2,435.9	1,785.5
Улаанбаатар	2,435.9	1,785.5

Эх сурвалж: СЯ, Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан 2020 он, Төсвийн сарын гүйцэтгэлийн мэдээ 2020 он

Орон нутгийн 2020 оны төсвийн гүйцэтгэлээр хүрээлэн буй орчны бодлого, удирдлага хөтөлбөрт 19,259.3 сая төгрөг төлөвлөж, 17,727.8 сая төгрөг зарцуулж, 92 хувийн биелэлттэй гарсан. Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага хөтөлбөрийн санхүүжилтийг 100 хувь урсгал зардалд зарцуулсан ба үүний 60.3 хувь буюу 10,697.5 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагаа, 36.6 хувь буюу 6,485.3 сая төгрөгийг байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, үлдсэн хэсэг нь ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг, хур хог хаягдал, орчны бохирдлыг устгах, цэвэрлэх үйлчилгээ, гэрээт ажиллагсад болон харуул, хамгаалалтын арга хэмжээнд тус тус зарцуулагдсан байна (Хүснэгт 30).

Хүснэгт 30. Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага хөтөлбөрийн 2020 оны арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, хувь

/сая төгрөг/

Хөтөлбөр, зориулалт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага	19,259.3	17,727.8	92.0%
Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	314.6	304.9	96.9%

Ахмадын сан	0.5	0.5	100.0%
Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх	7,029.0	6,485.3	92.3%
Бусад	9.8	9.8	100.0%
Гэрээт ажиллагсдын зардал	17.5	15.3	87.5%
Мэдээлэл, сурталчилгааны зардал	4.3	4.3	100.0%
Үндсэн үйл ажиллагааны зардал	11,640.0	10,697.5	91.9%
Харуул, хамгаалалтын зардал	52.9	50.6	95.5%
Хур хог хаягдал, орчны бохирдлыг устгах, цэвэрлэх үйлчилгээ	190.6	159.6	83.7%

Эх сурвалж: СЯ, Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан 2020 он, Төсвийн сарын гүйцэтгэлийн мэдээ 2020 он

Хүрээлэн буй орчны бохирдол, доройтол

Монгол улсын нутаг дээр амьтдын идээшил нутгийн хумигдал, тасархайтал, бохирдол, үс зэрэг амьдрал тэтгэх байгалийн нөөцийн хомсдол гэх мэт аюул, дарамтууд шинээр гарч ирж эрч хүчээ авч байна. Үүнд дараах хүчин зүйлс голлон нөлөөлж байна¹².


1. Хүн ам өсөж, хэрэгцээ, хэрэглээ нь улам эрчтэйгээр амьдралын тулгуур хэрэгцээг давсан байдлаар нэмэгдэж байна;
2. Малын тоо толгой өсөж, сүргийн бүтэц бэлчээрт халтай байдлаар өөрчлөгдөж байна;
3. Газар нутгийн тодорхой хэсгийг тариаланд ашиглаж түүнд химийн бордоо, гербицид, пестицид хэрэглэж орчинд дарамт үүсгэж байна;
4. Төмөр зам, цахилгаан дамжуулах шугам зэрэг дэд бүтцийн өргөжилт. Үүнд хамрагдаж буй газар нийт газар нутгийн 0.3%;
5. Биологийн олон янз байдалд халтай нөлөө бүхий уул уурхай хөгжиж амьдрах орчин, идээшил нутгийг хэсэгчлэн тасархайтуулж агаар, ус, хөрсийг бохирдуулах нөхцөлийг бүрдүүлж байна;
6. Шинээр хот суурин бий болж биологийн олон янз байдалд нэмэлт дарамт үүсгэж байна;
7. Уур амьсгалын өөрчлөлтийн эрчим биологийн олон янз байдалд нөлөөлөх хэмжээнд хүрч байна;
8. Биологийн олон янз байдалд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй эдийн засгийн татаас.

Засгийн газрын 2019 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн 318 дугаар тогтоолоор батлагдсан “Хөрс хамгаалах, газрын доройтлыг бууруулах үндэсний хөтөлбөр”-т хөрсний нөөцийг зохистой ашиглах, хамгаалах, газрын бохирдол доройтлоос урьдчилан сэргийлэх, нөхөн сэргээхэд чиглэсэн, үйл ажиллагааг хэрэгжүүлэх, урт хугацааны тогтвортой менежментийг бий болгох нийгэм, эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэх үндсэн зорилгын хүрээнд ажиллаж байна.

Хүрээлэн буй орчны бохирдол, доройтол хөтөлбөрт 2015-2020 онуудад нийт 7,516.7 сая төгрөг төлөвлөж, 7,319.6 сая төгрөг зарцуулж, 97 хувийн биелэлттэй гарсан. Хөтөлбөрт 2015-2018 онуудад орон нутгийн төсвөөс жилд дунджаар 1.0 тэрбум төгрөгөөс дээш санхүүжилт олгож байсан бол 2019-2020 онуудад хүрээлэн буй орчны бохирдол, доройтолд өгөх санхүүжилт харьцангуй буурч 2019 онд 244.6 сая төгрөг, 2020 онд 528.1 сая төгрөгөөр тус тус төлөвлөсөн байна (Зураг 33).

¹² Монгол улсын биологийн олон янз байдлын санхүүжилтийн хэрэгцээ, бодлого, хандлага (2019). НҮБХХ, БИОФИН төсөл
<https://www.mn.undp.org/content/mongolia/en/home/library/mongolia--biodiversity-finance-policy-and-institutional-review--.html>

Зураг 33. Хүрээлэн буй орчны бохирдол, доройтол хөтөлбөрийн 2015-2020 оны төлөвлөгөө, гүйцэтгэл



Эх сурвалж: СЯ, Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан 2015-2020 он

Хүрээлэн буй орчны бохирдол, доройтол хөтөлбөрийг 2020 онд Баян-Өлгий аймаг Байгаль орчин, аялал жуулчлалын газар болон Барьцаа гэсэн хоёр байгууллагад, Дорнод аймаг Засаг даргын тамгын газар байгууллагад төлөвлөж, зарцуулж байна. Бусад аймгуудад 2020 онд гүйцэтгэл гараагүй харин Улаанбаатар хотын хувьд Нийслэлийн Захирагчийн ажлын алба байгууллагад түс хөтөлбөрийг төлөвлөж, зарцуулж байна (Хүснэгт 31).

Хүснэгт 31. Хүрээлэн буй орчны бохирдол, доройтол хөтөлбөрийн 2020 оны төлөвлөгөө, гүйцэтгэл байгууллага болон аймгаар

/сая төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Хүрээлэн буй орчны бохирдол, доройтол	528.1	435.4
Байгаль орчин, аялал жуулчлалын газар	70.0	55.0
Баян-Өлгий	70.0	55.0
Барьцаа	31.9	10.3
Баян-Өлгий	31.9	10.3
Засаг даргын тамгын газар	56.2	34.7
Дорнод	56.2	34.7
Нийслэлийн Захирагчийн ажлын алба	370.0	335.4
Улаанбаатар	370.0	335.4

Эх сурвалж: СЯ, Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан 2020 он, Төсвийн сарын гүйцэтгэлийн мэдээ 2020 он

Аймаг, нийслэлд хүрээлэн буй орчны бохирдол, доройтол хөтөлбөрийг харилцан адилгүй, өөр өөр байгууллагад төлөвлөж, зарцуулж байгаа тул эрх бүхий дээд шатны байгууллагаас нэгдсэн

удирдамж, заавраар хангаж Засаг даргын тамгын газар, Нийслэлийн Захирагчийн ажлын алба зэрэг байгууллагаар дамжуулахгүй байх нь зүйтэй.

Орон нутгийн 2020 оны төсвийн гүйцэтгэлээр хүрээлэн буй орчны бохирдол, доройтол хөтөлбөрт 528.1 сая төгрөг төлөвлөж, 435.4 сая төгрөг зарцуулж, 82.4 хувийн биелэлттэй гарсан. Хүрээлэн буй орчны бохирдол, доройтол хөтөлбөрийн санхүүжилтийг 100 хувь урсгал зардалд зарцуулсан ба үүний 77 хувь буюу 335.4 сая төгрөгийг хур хог хаягдал, орчны бохирдлыг устгах, цэвэрлэх үйлчилгээ, 23 хувь буюу 100.0 сая төгрөгийг байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд тус тус зарцуулагдсан байна (Хүснэгт 32).

Хүснэгт 32. Хүрээлэн буй орчны бохирдол, доройтол хөтөлбөрийн 2020 оны арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, хувь

/сая төгрөг/			
Хөтөлбөр, зориулалт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
Хүрээлэн буй орчны бохирдол, доройтол	528.1	435.4	82.4%
Агаарын бохирдлыг бууруулах	10.0	-	0.0%
Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх	148.1	100.0	67.5%
Хур хог хаягдал, орчны бохирдлыг устгах, цэвэрлэх үйлчилгээ	370.0	335.4	90.6%

Эх сурвалж: СЯ, Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан 2020 он, Төсвийн сарын гүйцэтгэлийн мэдээ 2020 он

Монгол улсын хэмжээнд уул уурхайн олборлолтын үйл ажиллагааны улмаас нийт 27,912 га талбай уулын ажилд хамрагдсан. Үүнээс техникийн нөхөн сэргээлт хийсэн талбай нь 75 хувь буюу 20,846 га, биологийн нөхөн сэргээлт хийсэн талбайн хэмжээ 29 хувь буюу 7,973 га байна.

- 2017 оны байдлаар улсын хэмжээнд уул уурхайн үйлдвэрлэлийн улмаас 23,657.6 га талбай эвдрэлд өртсөнөөс 11,863.1 га талбайд техникийн, 6,458.2 га талбайд биологийн нөхөн сэргээлт хийгдсэн бөгөөд энэ нь нийт эвдрэлд орсон газрын 77.4 хувийг эзэлж байна. 2017 онд хийгдсэн нөхөн сэргээлтийн хэмжээг 2016 оныхтой харьцуулахад техникийн нөхөн сэргээлт 10.7 хувь, биологийн нөхөн сэргээлт 9.8 хувиар тус тус өссөн дүнтэй байна.
- 2018 онд 11 аймгийн 29 сум, нийслэлийн 4 дүүргийн нутагт 69 тусгай зөвшөөрөлтэй ААН, 7 нөхөн сэргээлтийн мэргэжлийн байгууллага, 1 ТББ, 4 нөхөрлөл, 1 холбоо, 328 иргэн 617 га-д техникийн, 465 га-д биологийн нөхөн сэргээлтийн ажил хийсэн байна. 2018 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд 396.3 га газарт техникийн нөхөн сэргээлт хийхээс хагас жилийн байдлаар 32 газрын хэвлийн нөхөн сэргээлтийн мэргэжлийн байгууллагын тайлан ирүүлээд байна.
- 2019 онд эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн ажлын дүнг нэгтгэхэд 10 аймгийн 18 сумын нутагт 25 тусгай зөвшөөрөлтэй ААН, 5 30 нөхөн сэргээлтийн мэргэжлийн байгууллага, 3 ТББ, 8 нөхөрлөл, 1 холбоо, 120 иргэн 374 га-д техникийн, 56 га-д биологийн нөхөн сэргээлтийн ажил хийсэн байна.

ДУГНЭЛТ, САНАЛ ЗӨВЛӨМЖ

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн шинжилгээтэй холбоотой дүгнэлт

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга байгалийн нөөц ашигласны төлбөр хураах эрх бүхий албан тушаалтныг томилон ажиллуулж, байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг 2013-2020 онуудад нийт 575.6 тэрбум төгрөг төлөвлөж, 613.5 тэрбум төгрөг бүрдүүлж, 107 хувийн гүйцэтгэлтэй гарсан. Орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн нийт орлогын 54.9 хувь ус, рашааны нөөц ашигласны төлбөр, 30.4 хувь газрын төлбөр, 7.5 хувь ойн нөөц ашигласны төлбөр, 4.3 хувь ан амьтны нөөц ашигласны төлбөр болон 1.8 хувь байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр тус тус эзэлж байна. Судалгааны үр дүнгээс харвал байгалийн нөөц ашигласны төлбөрийг орлогын дийлэнх буюу 85 орчим хувийг газрын төлбөр болон ус, рашааны нөөц ашигласны төлбөр эзэлж байна.

